

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 11 ДҮГЭЭР
САРЫН 09-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИИН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-25
2	<p>Дэлгэрэнгүй тэмдэглэл</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</p> <p>2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</p> <p>3. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</p>	26-78 26-38 38-75 76

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын
09-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны
төвч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Эрдэнэбат.

Нэг.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах шинжээч Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу санал хураалт явуулав.

Нэг.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Ж.Мөнхбат: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;” гэсэн саналыг гуравны хоёроор дэмжиж, дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Мөнхбат: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;” гэсэн саналыг гуравны хоёроор дэмжиж, дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;” гэсэн саналыг саналыг гуравны хоёроор дэмжиж, дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“; -хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“-мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал” гэсэн саналыг гуравны хоёроор дэмжиж, дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“-мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Жендерийн хөгжлийн асуудлыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэвээр үлдээх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Ж.Мөнхбат: Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн “Ойн судалгаа, хөгжлийн газар” гэснийг “Ойн газар” гэж өөрчлөх гэсэн саналыг гуравны хоёроор дэмжиж, дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12

91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн “Ойн судалгаа, хөгжлийн газар” гэснийг “Ойн газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“Цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого, зохицуулалт” гэсэн дээр “хүний эрхийг, эрхийг хамгаалах бодлого, зохицуулалт” гэж нэмэх гэсэн саналаа татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, С.Бямбацогт, Н.Энхболд нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх С.Эрдэнэчимэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ж.Мөнхбат: 1.Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, М.Оюунчимэг, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Н.Энхболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалтын “Засгийн газраас” гэснийг “Засгийн газар болон олон улсын байгууллагаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.Улсын Их Хурлын гишүүн өмнө болон одоо хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үйл ажиллагаатай холбогдох хяналт шалгалтын ажлын хэсэг, түр хорооны бүрэлдэхүүнд орохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.7.Байнгын хороо хяналт шалгалтын үр дүнд үндэслэн холбогдох санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг хасаж, төслийн дугаар өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.“төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим” гэж Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг алдагдуулахгүй байх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	6
Бүгд:	12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хэлбэр

9.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

9.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх, төсвийн хяналт, Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж цаглавар гаргана.

9.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, байгууллагын санал, гомдол, мэдээлэл, хяналт шалгалтын дүнг үндэслэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан Байнгын хорооны хяналт шалгалтын цаглаварт тусгаж хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар” гэснийг “албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмэх:

“11.3.Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хүлээлгэнэ.” гэснийг “хүлээлгэх үндэслэл болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “хэлэлцүүлэгт бэлтгэх шатны” гэснийг “нэг дэх хэлэлцүүлгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.5 дахь хэсэг нэмэх:

“21.5.Энэ хуулийн 23.4-т заасан тооцоог хийхэд шаардагдах Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг тухайн хугацаанд, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн задаргааг зардлын эдийн засгийн ангиллаар, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн задаргааны хамт тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх хугацаанаас өмнөх дараалсан 3 жилийн зэрэгцүүлсэн задаргааны хамт Улсын Их Хуралд ирүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийг “Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт” гэж, 22.2 дахь хэсгийн “гаргана.” гэснийг “гарган Улсын Их Хурлын гишүүдэд тараана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “хэлэлцүүлэг эхлэхээс өмнөх” гэснийг “хэлэлцүүлгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэг дэх хэлэлцүүлгээс” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг хасч, төслийн дугаар өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсгийн “таваас” гэснийг “есөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “таваас” гэснийг “есөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “таваас” гэснийг “есөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлгийн нэг, хоёрдугаар дэд бүлгийн гарчгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	5
Бүгд:	12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна:

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд,

Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны даргын албан тушаалд томилуулхаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаар томилгооны сонсгол;

29.1.2.хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол.

29.2.Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3.Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4.Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгох бөгөөд Байнгын хороо сонсголын сэдэв, нэр дэвшигчийн онцлогоос хамааран дэгээ өөрөө тогтоож болно.

29.5.Байнгын хорооны нэр дэвшигчийн сонсгол /цаашид “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31, 32 дугаар зүйлийг нэгтгэн, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30 дугаар зүйл.Сонсгол даргалагч, оролцогч

30.1.Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

- 30.1.1.сонсголын бэлтгэл хангах;
- 30.1.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, тогтоосон дэг сахиулах;
- 30.1.3.сонсголын дэг зөрчигчид хуульд заасан арга хэмжээ авах.

30.2.Сонсголд Нийтийн сонсголын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан оролцогчоос гадна нэр дэвшигч, түүнийг санал болгох эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөл оролцоно.

30.3.Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцох, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.17-д заасан нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журам, хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзнэ.

30.4.Байнгын хорооны гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу нэр дэвшигчтэй хамаарал бүхий этгээд бол энэ тухайгаа сонсгол эхлэхээс өмнө нийтэд мэдэгдэх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33, 34, 35, 36, 37, 38, 39 дүгээр зүйлийг нэгтгэн, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголын үе шат

31.1.Сонсгол доор дурдсан үе шаттай байна:

31.1.1.нэр дэвшигчийг санал болгох;

31.1.2.сонсголын тов тогтоох, зарлах;

31.1.3.сонсголын бэлтгэл хангах;

31.1.4.сонсголыг явуулах;

31.1.5.сонсголын тайлан гаргах;

31.1.6.сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах.

31.2.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтыг томилох, зөвшилцөх, танилцуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

31.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо энэ хуулийн 31.2-т заасан саналыг Улсын Их Хурлын чуулганы хугацаанд хүлээн авсан тохиолдолд ажлын 5 өдрийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан тохиолдолд ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор дараах ажиллагаа явуулна:

31.3.1 .сонсголын тов тогтоож, нийтэд мэдээлэх;

31.3.2.энэ хуулийн 31.2-т заасан санал, нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

31.4.Хэрэв тухайн Байнгын хороо өөрөө сонгон шалгаруулахаар хуульд заасан бол сонгон шалгаруулалтын дүнг гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо энэ хуулийн 31.3-т заасан ажиллагааг хийнэ.

31.5.Байнгын хороо энэ хуулийн 31.3, 31.4-т заасан ажиллагаа явуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн дотор сонсголд оролцогчдыг бүртгэх, нэр дэвшигчээс асуулт, саналыг бичгээр урьдчилан хүлээн авах бөгөөд шаардлагатай бол тухайн сонсголын дэгийг боловсруулж, батлах зэрэг сонсголын бэлтгэлийг хангана.

31.6.Нэр дэвшигчийг санал болгосноор сонсголын үе шат эхэлнэ. Энэ хуулийн 31.1.4-т заасан сонсгол явуулах хугацаа нь 3 хүртэл хоног үргэлжилж болно.

31.7.Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны олонх дэмжсэн тохиолдолд сонсголыг хаалттай явуулж болно.

31.8.Сонсголын тайланг сонсгол явуулснаас хойш ажлын 5 хоногт гаргах бөгөөд Байнгын хороонд танилцуулж, нэгдсэн хуралдаанд тараана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

24.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

“32 дугаар зүйл.Хяналтын сонсголыг хүчинтэйд тооцох

32.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцсоноор тухайн сонсголыг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	5
Бүгд:	12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын тавьсан асуултад Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Мөнхбат: 25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлгийн гарчгаас “/мөрдөн шалгах/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “мөрдөн шалгах арга хэрэгслээр” гэснийг “энэ хуулийн 46.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.9 дэх хэсгийн “хоёр” гэснийг “нэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ё.Баатарбилэг, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

33.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, “45.3.Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 45.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын

хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.9 дэх заалтын “газар дээр нь очиж үзэх,” гэсний дараа “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.	

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.11 дэх заалтын “тайлан,” гэсний дараа “санал, дүгнэлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.12 дахь заалтын “үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах” гэснийг “үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд холбогдох баримтыг хүргүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3, 48.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.2.Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахтай холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны тогтоол гарсанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Мөнхбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Монгол

Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	7
Бүгд:	11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

38.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, “48.2.Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахдаа холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийн олонхиын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	6
Бүгд:	11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: 38.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, “48.2.Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахдаа холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийн олонхиын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ж.Сүхбаатар, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	5
Бүгд:	10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: 38.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, “48.2.Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахдаа холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 55 дугаар зүйлийн 55.3.4 дэх заалтын “газар дээр нь очиж үзэх,” гэснийг “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	0
Бүгд:	10
100 хувийн саналаар дэмжигдлээ.	

Найруулгын санал:

Ж.Мөнхбат: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “гишүүний” гэсний өмнө “энэ хуулийн 13.4-т заасны дагуу гаргасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.1 дэх заалтын “хуульт ёсыг” гэснийг “хуулийг” гэж, мөн зүйлийн 4.1.2, 4.2.2 дахь заалтын “хангах” гэснийг “хамгаалах” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хэтрүүлж” гэснийг “хожимдож” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “тодорхой” гэснийг “хуульд заасан” гэж, мөн хэсгийн “Хурал” гэснийг “Хурлаас” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3, 44.6, 44.7, 44.8, 44.11 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1, 50.4 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1, 52.5 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.3, 55.6 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2, 61.4 дэх хэсэг, 67 дугаар

зүйлийн 67.2, 67.5, 67.6 дахь хэсэг, 68 дугаар зүйлийн 68.1, 68.3 дахь хэсгийн “мөрдөн” гэснийг “тусгай” гэж тус тус өөрчлөх.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “/мөрдөн шалгах/” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийг 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4, 20.5, 20.6, 20.7 дахь хэсгийн “дээд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	1
Бүгд:	10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн дараах томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал бүлэг зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Гурав. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Тав. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Зургаа. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Долоо. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Найм. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Ес. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арав. Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван нэг. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван хоёр. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван гурав. Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ж.Мөнхбат: 1.Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, М.Оюунчимэг, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Н.Энхболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн З дугаар зүйлийн “18 дугаар зүйлийн 18.5” гэсний дараа “,18.7” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “олонх” гэснийг “гуравны нэгээс доошгүй” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	5
Бүгд:	10
70.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Мөнхбат: 1.Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, М.Оюунчимэг, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Н.Энхболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн З дугаар зүйлийн “18 дугаар зүйлийн 18.5” гэсний дараа “,18.7” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “олонх” гэснийг “гуравны нэгээс доошгүй” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн З дугаар зүйлийн “гуравны нэгээс” гэснийг “еөөөс,” “таваас” гэснийг “еөөөс” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3

Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван зургаа.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван долоо.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван найм.Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван ес.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/Засгийн газар 2021.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан Б.Золбоо нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.МӨНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИИН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Мөнхбат: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц бурдсэн тул Байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. З асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт нарын 15 гишүүн 2021 оны 7 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Гуравдугаарт, Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 2021 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Танилцуулгыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал

2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан.

Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн нэгдүгээр зүйлд гаргасан зарчмын зөрүүтэй санал, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэж, хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах бодлого” гэж өөрчлөн найруулах, мөн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт нь Цахим хөгжил, харилцаа холбооны эрхлэх сайдын асуудлын хүрээнд “мэдээллийн технологийн салбарын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүний нөөцийн хөгжлийн асуудал” гэж өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу “хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт” гэж хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэмэх зарчмын зөрүүтэй саналыг ажлын хэсгээс гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хууль, тогтоолын төслийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлаас жендерийн хөгжлийн асуудлыг хасаж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудалд нэмж оруулахаар ирснийг мөн Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын эрхлэх асуудалд хэвээр үлдээх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзлээ.

Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Мөнхбат гэсэн ийм төсөл байна.

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналууд байна уу?

Та бүхэнд тараасан байгаа танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Энхболд гишүүн, Баярсайхан гишүүнээр тасаллаа. Баярсайхан гишүүн асууя.

Ц.Баярсайхан: Би зарчмын зөрүүтэй санал дээрээ ярих уу, эсвэл одоо шууд яриад эхэлчих юм уу? дарга аа.

Ж.Мөнхбат: Ажлын хэсэг танилцуулъя. Ганбат -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Мягмар -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Дондогмаа -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын ахлах шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураана.

Нэг.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах бодлого.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас гуравны хоёроор санал босно.

Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа, эрхэм гишүүд ээ, би чуулган дээр 2 зарчмын зөрүүтэй санал байна гээд саналын томьёоллоо бичээд ингээд ажлын хэсгийн даргад өгсөн байгаа. Энэ хуулийн төслийн 8-д Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх

асуудлын хүрээнд Хүний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлогоор хангах асуудал гэж ингэж оруулсан юм. Саяын ярьсан энэ хүн ам зүйн бодлого, хүний өсөлт бол өнөөдөр Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын чиг үүрэгт яг энэ үгээрээ орчихсон байж байгаа. Одоо тухайлбал, хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, стратегийн дунд, богино хугацааны бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах гээд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын чиг үүрэгт орчихсон байгаа юм. Тэгэхээр өнөөдөр өнгөрсөн 30 жилийнхээ бид нар хөгжлийн түүхийг дүгнэвэл эдийн засгийн хөгжил гэдгээ илүү түлхүү яриад хүний хөгжлөө орхигдуулчихсан.

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газарт хүний хөгжлийн цогц бодлого хариуцсан ийм институц байхгүй байгаад байгаа юм. Боловсролын яамыг хариуцна гэдэг Боловсролын яам болохоор боловсрол олгох чиглэл рүүгээ явчихдаг. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд гэхээр бид нар зүгээр хүний өсөлт хөгжил, хүн ам зүйн бодлого гэдгээ яриад ингээд явчихдаг. Тэгэхлээр эдийн засгийг авч явах тэр зөв хүнтэй байх, хүний хөгжлөө хариуцсан ийм институц байхгүй учраас хуучин Төлөвлөгөөний комисс гэж байхад эдийн засгийнхаа энэ бодлогыг аваад явахын хажуугаар хүний хөгжлөө бас давхар аваад явдаг байсан. Энэ уламжлалаа сэргээж хүнээ мартчихсан хүнээ орхичихсон байгаа энэ асуудал дээрээ бид нар онцгой анхаарч, Эдийн засгийн хөгжлийн яаманд энэ хүний хөгжил хариуцсан ийм бодлого оруулж өгөөч гэсэн миний хүсэл байгаа юм. Тэгэхгүй бол дахиад Хүний хөгжлийн яам гэж шинээр байгуулж чадахгүй. Хэчнээн эдийн засаг хөгжөөд хүн нь өнөөдөр чадваргүй, ёс зүйгүй ийм болчих юм бол тэр ямар ч эдийн засгийг аваад явах боломжгүй шүү дээ. Тэгэхлээр Монгол Улсын хамгийн гол үнэт баялаг болсон энэ хүний хөгжлийн цогц бодлогоо яг хэнд үлдээх гээд хэнд хариуцуулах гээд байгаа юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь, Монгол Ардын нам 2020 оны сонгуульд орохдоо нийгмийн хөгжлийн бодлогоо хүний хөгжлийн цогц бодлого болгож ингэж өөрчилж орсон. Засгийн газраас 2020-2024 оныхоо үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийн цогц бодлогыг боловсруулна гэж зорилт тавьчихсан явж байгаа, тэгээд энэ ажлууд бол ингээд жил гаруй хийгдэхгүй явж байгаа, хариуцдаг институц ерөөсөө байхгүй байгаа юм. Тийм учраас шинээр байгуулагдаж байгаа энэ Эдийн засгийн хөгжлийн яаманд хүний хөгжлийн бодлого хариуцсан ийм чиг үүрэгтэй байгаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Дараагийн яаман дээр гаргасан зарчмын зөрүүтэй саналаа дараагийнх дээр нь тайлбарлачих.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн санал хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгаяя. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэг дээр ч тэр, хэлэлцэх эсэх дээр ч тэр, энэ Чинзориг, Баярсайхан нарын гишүүд хүний хөгжлийн асуудлыг, хүний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудлыг энэ яамны чиг үүрэгт оруулж өгөөч гэж хүсэлт тавьж, санал гаргаж байсан юм. Үүний дагуу ажлын хэсэг хуралдаад анхны хэлэлцүүлэгт бэлтгэхдээ бид нар хоёр гол заалтыг оруулсан. Нэг нь хүн амын өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх гэсэн ийм томьёолол байсан. Хоёр дахь нь хүн амын

нутагшил, суурьшлын өрөнхий төлөвлөлтийг хийнэ гэдэг энэ хоёр чиг үүргийг энэ яаманд өгсөн.

Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр хүний хөгжлийн төлөвлөлт, бодлогын асуудлыг энэ яаманд ирээгүй байсан юм. Тийм учраас оруулж өгсөн. Сая анхны хэлэлцүүлэг хийгдэх үед мөн Чинзориг гишүүн, Баярсайхан гишүүн нар хүний хөгжлийг хангах асуудлыг оруулж өгмөөр байна гэсэн учраас бид нар ажлын хэсэг дээрээ яриад ажлын байрыг нэмэгдүүлэх нэгдсэн бодлого гэдгээ болиулаад хүний хөгжлийг хангах бодлого гэдгээ оруулж ирж байгаа юм. Сая Баярсайхан гишүүний яриад байгаа хүний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гэдэг энэ хүний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, салбар, салбар хоорондын болон бус нутгийн, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлогоор хангах гэдэг энэ өгүүлбэрийг бид нар хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого гэдэг дотор бүрэн орж байгаа гэж ойлгож байгаа юм. Монгол Улсад институт байхгүй бишээ, Баярсайхан гишүүн олон институт бий. Монгол Улсын Засгийн газар үндсэндээ бүрэн бүрэлдэхүүнээрээ л бүх чиг үүрэг нь хүний хөгжлийг хангахад чиглэгдэж байгаа. Энэ дотроо Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Соёлын яамдын үндсэндээ чиг үүрэг нь хүний хөгжлийг хангахад байгаа. Энэ нэгдсэн бодлого нь энэ яаман дээр ирнэ. Хэрэгжүүлэх ажил нь тэр бусад саяын нэрлэдэг яамдууд дээр байх юм.

Тийм учраас бид нар Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулж байх явцдаа мөн өмнөх хэлэлцүүлэг дээр байгаа, Та харсан бол. Аль аль яам нь юу юу хариуцах вэ гэдэг дээр нь өмнө нь бодлого, төлөвлөлт гэсэн байсан үгнүүдийг нь бүгдийг нь энэ яам руу аваад хэрэгжүүлэх, зохион байгуулах үр дүн, хяналт гэдэг ийм юмнуудаа солиод, солиод явчихсан байгаа чиг үүрэг дээр нь. Тийм учраас одоо бол үүнээс хойш хүний хөгжлийн бодлого төлөвлөлт бол энэ яаман дээр хэрэгжүүлэх, хяналт тавих, үйл ажиллагаа зохион байгуулах үүрэг нь бол салбарын яаман дээр байх юм.

Ж.Мөнхбат: Гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Баярсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал, ажлын хэсэг дахиж ажиллаад үндсэндээ нэгтгээд оруулж ирж байгаа гэж ойлгож байна Тогтохсүрэн дарга аа, тийм ээ. Өөрөөр хэлбэл хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого дотор энэ бодлого явж байна гэж ингэж үзэж байна уу. Орсон гэж үзвэл үүгээр одоо ингээд санал хураагдах нь, ороогүй байна гэж үзвэл Баярсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураах болж байна.

Дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн бол энэ зохицуулалтаар одоо бид санал хураана. Өөрөөр хэлбэл ажлын хэсгээс энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг өөрчлөн найруулж оруулж ирж хэлэлцүүлээч гэсэн ийм горимын санал гаргаж байгаа юм байна. Тийм учраас гуравны хоёр нь дэмжигдвэл энэ оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй саналыг бид нар цаашдаа энгийн горимоор хэлэлцээд санал хураагаад явах боломж бүрдэнэ гэсэн үг. Дэгийн тухай хуулийн 42.2.3-аар.

Ингээд ажлын хэсгээс оруулж ирсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Одоо эхлээд горимын саналаа хурааж байгаа. 42.2.3-аар, тэгээд гуравны хоёроор дэмжчих юм бол үүнийгээ дахиад хэлэлцээд явна.

Ингээд ажлын хэсгээс оруулж ирсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гуравны хоёроор дэмжвэл энэ саналаар санал хураалт явуулна гэсэн үг. Санал хураалт.

13 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 53.8 хувийн санал.

Гуравны хоёроор би одоо гурав дахин хэллээ шүү дээ. Анхааралтай байна шүү. Амарсайхан гишүүний санал. За Их Хурлын дарга Занданшатар дарга.

Г.Занданшатар: Энэ асуудлаар Чуулганы нэгдсэн хуралдаанаар гүйцээн боловсруулах чиглэл өгсөн гэж Төрийн байгуулалтын байнгын хороо ажилласан.

Өгөөгүй юмуу? Тэгэхдээ энд хүн амын хөгжлийн бодлого гээд Улсын Их Хурлын тухай хуульд хүн амын хөгжлийн бодлого гэж байгаа юм. Хүний хөгжлийн бодлого гэж ингээд баримт бичгүүд, тэгэхдээ энэ хуучин Төлөвлөгөөний комиссын ажил яах вэ, зүгээр энэ дашрамд онцлоод хэлчихэд хүн амын өсөлтөө тооцоод энэ жил тэдэн хүүхэд төрнө гэхэд хэдэн ширхэг өлгий хэрэгтэй болно, өлгийг дотооддоо тэдийг, гадаадаас тэд гээд дотоод, гадаад худалдаа, тэдэн мал өснө, төл тэдийг авна. Тэдэн төл авахад одоо худалдаа бэлтгэлийн анги, дотоод худалдан авалт, худалдаа бэлтгэлийн ангиудаар дамжих Худалдаа үйлдвэрийн яам гэж байсан. Гадаад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны яам гэж байсан. Энэ нь бүгд ингэж хүн амын хөгжилтэйгээ салшгүй холбоотой байх ёстай. Тийм учраас энэ яамны нэрийг Эдийн засаг, хөгжлийн яам боллоо гэж хууль санаачлагч Бямбацогт гишүүн чуулган дээр хэлж байсан. Тэгээд үүнийг гуравны хоёроор гүйцээн боловсруулаад олонхын саналаар шийдэх юм уу гэж бодсон. Заавал тийм чиглэл өгөөгүй юм байна. Тэгэхээр гуравны хоёроороо дэмжээд бас энэ бодлого төлөвлөлтийн асуудал, хүн амын төлөвлөлтийн асуудал нь энэ яамтайгаа уялдах нь. Хөгжил гэдэг бол хүний л хөгжилтэй холбоотой асуудал юм чинь эдийн засгийн төсөлтэй уялдуулчих нь энэ ажлын хэсгээс ирсэн саналыг дэмжээд дахин хураалгах санал гаргаж байна.

Түрүүний саналыг хүчингүйд тооцох, манай зарим гишүүдэд бас ойлголтын зөрүү болон тэгээд бас техникийн саатал шалтгаалсан учраас хүчингүй болгож өгнө үү гэсэн саналтай байна.

Ж.Мөнхбат: Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гарсан учраас горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Сүхбаатар гишүүн. Горимын саналын дагуу өмнөх санал хураалтыг хүчингүй болгох тухай санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар санал дэмжигдэж өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Одоо ажлын хэсгийн гаргасан горимын саналаар санал хураая. Энэ саналыг гуравны хоёроор дэмжих, дэмжсэн нөхцөлд Дэгийн тухай хуулийн 42.2.3-аар ажлын хэсгийн оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй санал дээр санал хураах боломж үүснэ.

Ингээд горимын саналаар санал хураалт явуулья. Дэмжье гэсэн саналын томьёоллоор гуравны хоёроор болсон шүү. Санал хураалт.

Ж.Мөнхбат: Шадар сайд Амарсайхан санал гаргая.

С.Амарсайхан: Сая дэмжиж өгсөн санал дэмжигдээгүйгээр явсан учраас саяын саналыг хүчингүй болгож дахиж санал хураалгах горимын санал гаргаж байна.

Ж.Мөнхбат: Ингээд Амарсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

12 гишүүнээс 8 гишүүн дэмжиж өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Одоо горимын саналаар санал хураалт явуулья. Ажлын хэсгээс оруулж ирсэн горимын саналаар санал хураалт явуулья. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас ажлын хэсгийн оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураана. Тогтохсүрэн гишүүний гаргаж байгаа санал бас зөв шүү. Засгийн газрын асуудал оруулж ирсэн асуудал хэлэлцэж байх үед Засгийн газрын гишүүд ирж Байнгын хорооны хуралдаанд суух ёстой. Тийм учраас Байнгын хороонд байдаг Засгийн газрын гишүүдийг дууддья.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого” гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Баярсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал энэ дотор нийцэж байгаа биз дээ.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн хоёрдугаар асуудал дээр.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт”

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас дэгийн хуулийн дагуу энгийнээр одоо дэмжигдэж явна. Энгийн горимоор санал хураалт явуулья. Ажлын хэсгийн оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 91,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“Мэдээллийн технологийн салбарын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн хөгжлийн асуудал”

Ажлын хэсгээс ийм зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирж байгаа. Энэ дээр Баярсайхан гишүүн бас санал гаргасан байгаа. Энэ гүйцээн боловсруулах чиглэл өгөгдөөгүй учраас дэгийн хуулийн 42.2.3-т заасны дагуу гуравны хоёроор санал босно.

Баярсайхан гишүүн саналаа тайлбарлах уу.

Ажлын хэсгээс оруулж ирсэн горимын саналаар санал хураалт явуулья. Энэ саналыг гуравны хоёроор босгох учраас дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт.

10 гишүүн дэмжиж 83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн учраас гуравдугаар зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг нэмэх:

“Мэдээллийн технологийн салбарын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн хөгжлийн асуудал”

Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ санал дээр Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Эхний Эдийн засаг хөгжлийн яам гэж байгаа. Тэнд сая бид нар хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах бодлого гээд оруулчихлаа. Хариуцах үндсэн чиг үүрэгт нь. Одоо Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд тийм үү? Мэдээллийн технологийн салбарын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн хөгжлийн асуудал гээд. Тэгээд үүнийг бас нэлэнх найруулахгүй бол хүний хөгжлийг хангах бодлого, хүний нөөцийн хөгжлийн асуудал дээр бас бodoх ёстой байх шүү. Тэгэхгүй бол ингээд сүүлд нь чиг үүрэг нь ойлгомжтой ч юм шиг, ойлгомжгүй ч юм шиг нэг иймэрхүү байдал үүсэж магадгүй. Уг нь агуулгаараа бол уншигдах гээд байгаа юм. Ерөөсөө мэдээллийн технологийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хариуцна. Мэдээллийн технологийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхжуулах, хөгжүүлэх, энэ салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх асуудал гэдгээр нь бол ойлгогдох байх.

Гэтэл үүнийгээ зөв томьёолж, найруулгын хувьд давхацсан чиг үүрэгтэй юм шиг ойлгомжгүй харагдах гээд байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологийн салбарын ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах, сургах дадлагажуулах, тогтвортуулж ажиллуулах гэсэн бодлогоо энэ салбарынхаа хүмүүст илүү анхаарах

ёстай шүү гэдэг агуулгаар томьёологох байх л даа. Тэгээд хэт ерөнхий болчихсон байна.

Ж.Мөнхбат: Бямбацогт гишүүний гаргаж байгаа санал бас чухал санал.

Тогтохсүрэн ажлын хэсгийн дарга.

Д.Тогтохсүрэн: Үүнийг өмнө нь ажлын хэсэг дээр Мөнх-Оргил гишүүн ингэж оруулж ирсэн юм Бямбацог дарга аа, энэ уг нь зөв байсан чинь, энэ дээр зас гэсэн чиглэл өгөөд ингэж оруулж ирсэн юм. Мэдээлэл технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой суурьшилтай ажиллуулахыг дэмжих гэсэн өгүүлбэр байсан юм. Тэгсэн чинь үүнийг зас гээд чиглэл өгчихсөн учраас ний нуугүй хэлэхэд манай ажлын дэд хэсгийнхэн хоёр байрыг нь сольчихсон. Уг нь энэ их чухал өгүүлбэр ийм байсан юм. Мэдээлэл технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой суурьшилтай ажиллуулахыг дэмжих гэдэг өгүүлбэр байсан юм.

Тэгвэл мэдээлэл технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, энэ салбарт хамгийн чухал нь тогтвортой суурьшил байгаа юм. Мэдээллийн технологийн салбар нь тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гээд бид нар ингэж болгож оруулсан юм. Энэ хүний нөөцийн асуудал сүүлд ийм болгосон юм. Эхэндээ бол нөгөөдөх нь өмнөө байсан юм.

Ж.Мөнхбат: Бямбацогт гишүүнд нэмэлт минут.

С.Бямбацогт: Тэгэхээр сая ерөнхийдөө ойлголтоо авчихлаа бүгдээрээ. Тийм болохоор мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал гээд. Ингэвэл илүү ойлгомжтой болж байгаа.

Ж.Мөнхбат: Гуравдугаар асуудлаар Байнгын хороон дээр санал хурааж санал дэмжигдсэн. Тийм учраас ажлын хэсэг сая Бямбацогт гишүүний гаргаж байгаа саналыг авч, энэ томьёолол дээр найруулгын хувьд нь засварлаад нэгдсэн чуулганд оруулъя.

Дөрөвдүгээр санал хураалт, энгийн горимоор шийдэгдэнэ. Гүйцээн боловсруулах чиглэл өгөгдсөн хууль, тогтоолын төслийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлаас жендерийн хөгжлийн асуудлыг хасаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудалд нэмэхээр оруулж ирснийг Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын эрхлэх асуудалд хэвээр үлдээх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй санал байна.

Санал хураалт энгийн горимоор явагдана. Санал хураалт.

12 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Жендерийн үндэсний хороо Ерөнхий сайдад байхаар санал буцаагдаж байна.

Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн санал хэлнэ.

Д.Тогтохсүрэн: 5 дугаар зарчмын зөрүүтэй санал байгаа юм. Нөгөө агентлагийнхаа нэрийг өөрчилье гээд Засгийн газраас санал гаргаад байгаа юм. Тэгээд бид нар сая ярилцаад, үүнийг зарчмын зөрүүтэй санал оруулаад хураалгачихъя гэсэн юм. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын 1 дүгээр зүйлийн “оин судалгаа, хөгжлийн газар” гэснийг “оин газар” гэж өөрчлөх, “оин судалгаа хөгжлийн газар” гэснийг “оин газар” гэж өөрчлөх гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналыг тавдугаар санал болгож ажлын хэсгээс оруулж байгаа юм. Санал хураалгаж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн ахлагчаас гаргаж байгаа горимын санал дэмжигдвэл зарчмын зөрүүтэй санал хураагдана. Төсвийн байнгын хороон дээр ингэж ороод дэмжигдчихсэн юм байна. Тийм учраас төсвийг дагасан хууль дээр нь ингэж явж байгаа учраас “оин бодлого хөгжлийн газар” гэснийг “оин газар” гэж өөрчилж байгаа нэршлийн хувьд.

Ингээд ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулья. Санал хураалт гуравны хоёроор дэмжигдэнэ шүү. Манайх анхааралтай байгаарай.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас ажлын хэсгийн ахлагчийн гаргасан “оин судалгаа хөгжлийн газрыг” “оин газар” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулья.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Оин бодлого хөгжлийн газар” гэсэн нь “оин газар” болж өөрчлөгдлөө. Санал дэмжигдлээ.

Мөн манай Байнгын хороон дээр оин газрын орон тоог 26-гаар нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй санал гаргах ийм хүсэлт ирсэн юм. Үүнийг манай Байнгын хороо шийдэхгүй. Энэ бол Төсвийн байнгын хороон дээр шийдэгдэх асуудал байгаа юм.

Мөн Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.4 дээр, батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтооно гэж заасан. Мөн Агентлагийн тухай эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дээр агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд батална гээд энэ хэсгийг 2012 оны 8 сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ийм хуулийн заалт байж байгаа.

Тийм учраас энэ салбарын сайд өөрөө агентлагаа байгуулаад, агентлагийн даргатайгаа яриад бүтцээ хийгээд орон тоогоо тавиад шийдээд явах бүрэн боломжтой. Төсөв нь өөрөө яаман дээр байгаа бүтцээ төсвөөсөө шийдээд явъя гэж байгаа. Тэгэхээр ийм боломж нь нээлттэй байгаа.

Баярсайхан гишүүн санал гаргана.

Б.Баярсайхан: Баярлалаа. Тэгээд хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлоготой болгох ийм зохицуулалт оруулж өгч байгаа. Манай энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд цахим орчинд хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого зохицуулалт гэсэн дээр хүний эрхийг хүүхдийн эрхийг хамгаалах бодлого зохицуулалт гэж оруулж өгөөч гэж би ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Яагаад гэвэл өнөөдөр хүүхдүүд 4 наснаасаа гар утас хэрэглэж байгаа. Цахим гадуурхлаас болж нас барж байгаа хүүхдүүдийн тоо 4 жилд 100 гаруй даваад явчихсан. Амиа хорлолт энэ цахим гадуурхал ерөнхий боловсролын сургуульд маш их байгаа. Энэ нь одоо бүр ингээд 4 наснаас эхлээд явж байгаа учраас нэгэнт одоо ийм бүхэл бүтэн яамтай болж байгаа юм чинь хувийн мэдээлэл гэдэг нэг өөр. Хүний эрхийн асуудал гэдэг чинь өөр учраас хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах бодлого зохицуулалт гэдэг энэ зүйл заалтыг нэмж өгөөч гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал оруулсан юм. Дэмжиж өгнө үү, баярлалаа.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн Баярсайханы гаргасан зарчмын зөрүүтэй санал байна. Хуулийн төслийн 16-д Цахим хөгжил, харилцаа холбооны сайд гэдэг дээр цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах, цахим орчин дахь хүчирхийллийн эсрэг хүүхэд хамгаалах бодлого, зохицуулалт гэж оруульяа гэсэн санал гаргажээ.

Энэ санал дээр Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Хүний эрх Үндсэн хуульд заасан 18 эрх, мөн дээрээс нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль бил нар батлаад, одоо бүх хуулиуд нь үндсэндээ хүний эрхийн мэдрэмжтэй хууль болгох чиглэлээр бас тодорхой ажлууд хийгдэж байгаа. Тэгээд энэ хүрээнд бол Хүний эрхийн үндэсний комисс гэж байгууллага, Монгол Улс маань хүний эрхийн үндэсний комисс нэгдсэнтэй холбоотойгоор маш том, одоо хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй байгууллага байгаад байгаа юм. Тэгэхээр аливаа нэг байгууллагын чиг үүргийг ингээд хоёр, гурав салгаад, тэгээд тодорхойгүй байдал үүсээд давхардаад эхэлбэл эргээд нөгөө ажил цалгарддаг. Манай байгууллагын хүлээсэн үүрэг биш, цахим орчин дахь хүний эрхийн асуудал бол одоо Цахим хөгжлийн яамны асуудал гээд Хүний эрхийн үндэсний комисс л өгчихдөг. Буух эзэн гээд буцах хаягтай яг тодорхой хариуцах эзэнтэй л байх хэрэгтэй.

Тийм болохоор Хүний эрхийн үндэсний комисст үндэсний хүний эрхтэй бүх асуудал зангидаад байгаа. Сая Хууль зүйн байнгын хороон дээр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль гээд хуулиуд хэлэлцсэн. Энэ дээр үндсэндээ хүний эрхтэй холбоотой асуудлыг Хүний эрхийн үндэсний комиссын санал дээр үндэслэж Цахим хөгжлийн яаманд журам, заавраа баталж, уялдуулж өгч байгаа юм л даа. Тийм болохоор хүний эрхийг хамгаалах асуудал биш, мэдээж цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого, зохицуулалт гэдгийн цаад талд нь үндсэндээ Хүний эрхийн үндэсний комисс энэ Цахим хөгжлийн яам хоёр маань одоо үйл ажиллагаагаа уялдуулаад явчих бололцоо бусад хуулиудаар байж байгаа болохоор яг энэ дотор хүний эрхийг хамгаалах ёстой шүү гэдэг байдлаар энэ яаманд орж ирэх нь тийм зохимжтой биш болов уу л гэж бодох юм.

Н.Энхболд: Би Бямбацогт гишүүний саналыг дэмжиж байгаа. Энэ шинэ яамыг ер нь технологи талаас нь хөгжүүлж бүтцийг нь бий болгох, энгийнээр бол талтай холбоотой юмаа хөгжүүлэх ийм яам шүү дээ. Хариуцаж байгаа хүний эрх, бусад зүйл энэ юмнууд нь бол холбогдох албан журмаараа явах нь зүйтэй. Юм болгон дээр аваачиж, юм болгоныг чихэх хэрэг байхгүй гэж бодож байна. Ялангуяа энэ дээр цахим орчноор дамжаад одоо нийгэмд үүсээд байгаа хүний хувийн нөөцтэй холбоотой асуудлуудыг хамгаалахад энэ технологиороо дамжаад хийгдэх ажлууд байгаа юм. Би энэ яамыг байгуулж байгаа гол зорилго нь технологийн хөгжлийн талаас нь дэмжих ийм л яам гэж бодож байгаа болохоос биш бүх юм руу орж байдаг цахим орчноор, цахим технологиор дамжуулж тэр бусад асуудлуудыг шийддэг яам гэж ерөөсөө харахгүй байгаа. Тэгж саналаа өгсөн. Тэгэхээр би бүх юман дээр ингээд энэ юмнуудыг оруулаад байх нь тийм зохистой асуудал биш гэж бодож байна.

Хоёрдугаарт дээр нь бас миний хэлэх гэж хэлсэн юмнууд энэ асуудлуудыг хариуцдаг байгууллагууд бий болчихсон, хуулиуд нь шинэчлэгдчихсэн тэгээд энэ сүүлдээ эзэнгүй болчихдог юм. Одоо бид нар хамгаалах гэсэн чинь цахим яам яагаагүй шүү дээ ч гэдэг юм уу, эсхүл цахим хүний эрхийн комисс юм хийгээгүй байхад бид нар энийг чинь энд нь тойрсон энд нь таарсан арга хэрэгслийг нь гаргахад хэцүү шүү дээ гэдэг юм уу ийм юмнууд болдог юм. Тийм учраас хариуцсан хариуцсан газраа юм нь байгаа. Энэ яамаа гол нь тэр сая миний эхний хэлсэн зорилгоор байгуулагдаж байгаа гэдэг агуулгад нь нийцүүлээд явах нь зүйтэй байх. Юм болгон дээр тэрийг оруулж хэрэггүй гэж бодож байна.

Ж.Мөнхбат: Баярсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж гишүүд үг хэллээ.

Гишүүн саналаа татах уу, эсвэл санал хураалгах уу? Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Гишүүддээ баярлалаа. Нэгэнт ингэж санал гарч байгаа, нэг талаасаа бол мэдээж бас бodoх асуудал. Нөгөө талаасаа өнөөдөр дэлхий өртөнцөд одоо амьд байгаа харилцаанд байгаа хүмүүсийн ихэнх цаг нь бол цахим орчинд явагддаг болсон. Тэгээд цахим орчинд хүнээ хамгаалах, ялангуяа одоо энд маш их өртөж байгаа хүүхдүүдээ хамгаалах бодлого өнөөдөр Хүүхэд хамгааллын хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, энэ хүчирхийллийн эсрэг хуулиудад ерөөсөө зүйл, заалт тусгагдаагүй байгаа. Тэгээд гишүүний хувьд цахим орчинд хүний эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг хамгаалах энэ хуулийг одоо санаачлаад холбогдох хуулиудад нь бас нэмэлт, өөрчлөлт оруулах энэ ажил дээр бас ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Тэгээд хамгийн гол нь тэр технологи гэдгээ одоо аваад явж байгаа яамны хувьд энэ шилдэг технологиороо хүүхдүүдээ яаж хамгаалах юм, энэ хүүхдүүдийг хүчирхийлээд байгаа энэ асуудлуудыг яаж одоо цэгцлэх юм бэ гэдэг асуудал өнөөдөр яг хоосон хоцорч байгаа шүү. Дандаа кибер аюултай тэмцэх гэдэг юм уу, Цагдаагийн өрөнхий газар нь тийшээ явчхаад байдаг. Гэтэл сургуульдаа ч тэр, эцэг эхийн хувьд ч тэр сошиал орчинд хүүхдүүдээ хүчирхийлүүлж байгааг мэдээгүй. Одоо ямар ачаа үүрээд явж байгааг мэдэх ч үгүй ийм явж байгаа шүү. Ирээдүйн хүүхдүүд маань гаднаа шарахгүй ч дотроо одоо сэтгэлийн шархтай энийг зохицуулах ямар ч зохицуулалт байхгүй явж байгаа шүү гэдгийг би энэ хурал дээр бас онцлоод хэлье гэж бодож байна. Тэгээд баярлалаа, саналаа татаж байна.

Ж.Мөнхбат: Баярлалаа. Баярсайхан гишүүн өөрийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа татаж байгаа учраас санал хураалт явагдахгүй.

Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай нэмэлт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг танилцуулна.

Дараагийн асуудалд орьё.

Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Хэд хоногийн өмнөх хуралдаан дээр анхны хэлэлцүүлэг хийгээд ажлын хэсэгт чиглэл өгсөн байгаа, хугацаатай. 2021 оны 7 сарын 7-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж шийдвэрлэсэн.

Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор төслийн 10,13, 14, 15, 16 болон 69 дүгээр зүйлд холбогдох нийт 9 санал хурааж, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хийж, Төрийн байгуулалтын байнгын хороо болон ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг боловсруулж анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэхээр тогтсон.

Энэ хүрээнд дэд ажлын хэсэг 10 дугаар сарын 28, 29, 11 дүгээр сарын 1, 2, 3, 8-ны өдрүүдэд нийт 6 удаа, гишүүдийн ажлын хэсэг 11 сарын 1, 4, 8-ны өдрүүдэд тус тус хуралдаж, Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн төсөлд холбогдох зарчмын зөрүүтэй 37 санал, найруулгын санал 3, хамт өргөн мэдүүлсэн Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох зарчмын зөрүүтэй санал 4, Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлэгт холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулахтай холбоотой санал 1, нийт 45 санал бэлтгэн өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр та бүхэн тараасан болно.

Зарчмын зөрүүтэй 37 саналаас, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зарчимтай холбоотой 2, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд, хяналт тавих асуудлыг тодруулсан санал 2, хяналт

шалгалтын төлөвлөгөө болон төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрийн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 1, Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 2, гишүүний асуулт, асуулгын талаарх төслийн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 2, төсвийн хяналт, хяналттай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 5, нэр дэвшигчийн сонсголтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 10, Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хянан шалгах түр хороотой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой 9 саналыг тус тус боловсруулсан болно.

Та бүхэнд тараасан зарчмын зөрүүтэй 16 дахь саналд заасан хяналтын сонсгол явуулах санаачилга гаргах босгыг 5-9 болгон нэмэгдүүлэх санал дэмжигдсэнтэй холбоотойгоор төсөлд хамт өргөн мэдүүлсэн Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох 4 зарчмын зөрүүтэй саналаар санал хураана.

Түүнчлэн зарчмын зөрүүтэй саналын 19 дэх саналыг нэгдсэн хуралдаан дэмжсэн тохиолдолд төслийн эцсийн хэлэлцүүлгийн үеэр хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах асуудлаар санал хураах шаардлага үүсэх юм.

Саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү?

Ж.Мөнхбат: Дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан. Тийм учраас хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно гэсэн дэгийн зохицуулалт байгаа. Одоо хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төслийн нэгдүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Төрийн байгуулалтын байнгын хороо 10 сарын 27-ны өдөр санал хураасан.

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар заалт дээр мөн 10 сарын 27-нд Байнгын хороо санал хураасан.

Асуулт, саналтай гишүүн алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр мөн санал хураасан.

Асуулт, санал алга байна.

Одоо хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Бямбацогт гишүүнээр тасаллаа. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Ер нь хууль санаачлагчийн хувьд үндэслэлээ тайлбарлачихъя гэж байгаа юм. Ер нь бид нар бас хуулиудын тодорхой зарчмыг суулгаж өгье гээд. Одоо Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Улсын

Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулиуд гээд хуулиудын үндсэндээ бас тодорхой зарчмууд оруулж ирж байгаа. Нэлээн бас ярьж байж, нэлээн бодож байж илүү аль болох зарчим нь ерөнхий байх ёстой гэдэг агуулгаар, тэгээд энэ хүрээндээ үндсэндээ 4.2.3, 4.1.3 дээр төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг хангах гээд төрийн эрх мэдэл хоорондын тэнцлийг баримтлах зарчим гэдэг дээр Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байх. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх, шүүх, засаглалынхаа ажиллагаанд оролцохгүй. Өөрөө Улсын Их Хурал хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд Үндсэн хуульд заасан хүрээнд үйл ажиллагаа явуулна. Энэ хүрээ хязгаараас хальтирч болохгүй шүү гэдгээ уг нь тодотгоод энэ зарчмыг барина гээд. Үүн дээрээ гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байна, гүйцэтгэх эрх мэдлээ хутгалдахгүй шүү. Засгийн газрын ажил руу, шүүх эрх мэдэл рүү хутгалдахгүй шүү. Тэгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах үйл ажиллагаанд оролцохгүй шүү гээд уг нь тодорхой ерөнхий оруулаад өгчихсөн юм.

Гэтэл ажлын хэсэг маань энэ дээр задлахдаа нэлээн задалчихсан байна. Үндсэн хуулиар тогтоосон эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байх гэчхээд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тогтоосон чиг үүрэг болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг гээд ингээд л нарийвчлах тусам чинь л цаад талд нэг онгорхой цоорхой нэг цонх үлдчих гээд байдаг. Одоо энэ тэр үлдчихсэн байна шүү, одоо энд болох юм байна шүү гэж. Ерөнхий байвал ерөнхий утгаараа ингээд асуудал маань нэлээн сайн ерөнхий зарчмаар орж байгаа учраас гайгүй болчихмоор байдаг. Гэтэл нарийвчлаад л тодорхой болгоод байх тусам цаад талд нь нарийвчлагдаагүй юм гээгдээд байдаг л даа. Нэг ийм юм болчих вий дээ гэдэг агуулгаар ажлын хэсгээс асууж байгаа юм.

Ж.Мөнхбат: Ардчиллын амин сүнс гэдэг энэ нэг засаглал хуваах зарчмын асуудалтай холбоотой асуултыг хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт асуулаа. Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хариулья.

Ж.Сүхбаатар: Хууль санаачлагч маань энэ дээр ингэж асууж байна. Энэ ажлын хэсэг бол мэдээж нөгөө хамтаараа ярилцаад шийддэг. Яг тодруулж хэлбэл Нямаагийн Энхболд гишүүн бас ингээд тодруулъя гэдэг санал гаргаад, тэгээд ажлын хэсгийн гишүүдээр дэмжигдчихсэн юм. Гол нь ингээд тодруулж бичиж байна гээд. Тэгээд үүнийг нь Н.Энхболд гишүүн уг нь ажлын хэсгийн гишүүн, дуудчихгүй юу. Тэгээд Энхболд гишүүний санал гээд дэмжигдсэн юм. Тийм тэгээд яах вэ? Ажлын хэсгийн санал болно шүү дээ. Олонх нь дэмжчихсэн болохоор ингээд тодруулаад биччихье л гэсэн юм. Тэгээд гол юм нь Улсын Их Хурал маань бас ингээд ажлаа хийж байхдаа нөгөө эрх мэдлээ хуваарилах гээд Авлигатай тэмцэх, шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурорын ажлууд руу хутгалдаж ороод байхгүйг л тодруулж хэлж байна гэж ойлгоод, ингэхэд юу нь буруу байх вэ гээд л ажлын хэсгийн гишүүд дэмжчихсэн байна.

Ер нь бол таны хэлдэг тэр өмнөх ерөнхий заалтын хүрээнд хийгдчихсэн байсан, гол нь нөгөө гүйцэтгэх шүүх эрх мэдлийг л оруулахгүй шүү гэчихсэн. Үүнийг ингэж бүр тодруулж заасан юм байна. Тэгсэн одоо аль болохоор Хяналт шалгалтын тухай хуульд, ер нь дашрамд хэлэхэд Улсын Их Хуралд хамгийн олон сонгогдсон

гишүүнийх нь хувьд саналуудыг нь бид нар нэлээн хүндэтгэлтэй авч үзсэн байгаа. Тэгээд өөрөө оролцоод идэвхтэй нэлээн явсан юм байгаа.

Ж.Мөнхбат: Энхболд гишүүнийг дуудсан уу? Би ажлын хэсгийн нэрс танилцуулъя. Мөнхсайхан -Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач хүрэлцэн ирсэн байна. Энхболд гишүүний саналыг орж ирэхээр явъя.

Дараагийн санал руугаа ороод явж байя. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Адъяасүрэн, Баатарбилэг, Ганболд, Оюунчимэг, Мөнх-Оргил, Пүрэвдорж, Сүхбаатар, Энхболд /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ саналын томьёолол дээр.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын Засгийн газраас хараат бус гэснийг Засгийн газар болон олон улсын байгууллагаас гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Сая нэр дурдсан ажлын хэсгийн нэр бүхий гишүүд байгаа.

Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулья. Санал хураалт.

100 хувийн саналаар санал дэмжигдсэн байна. 10 гишүүн санал хураалтад оролцож санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, Алга байна.

Төслийн 6 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Ажлын хэсгээс санал байгаа юм байна.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

6.2.Улсын Их Хурлын гишүүн өмнө нь болон одоо хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үйл ажиллагаатай холбогдох хяналт шалгалтын ажлын хэсэг түр хорооны бүрэлдэхүүнд орохгүй.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

10 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, Алга байна. Төслийн 8 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Ажлын хэсгийн санал байна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

8.7. Байнгын хороо хяналт шалгалтын үр дүнд үндэслэн холбогдох санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

10 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 70,0 хувийн саналаар санал дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүн дэмжсэн. Санал өгсөн протокол тэмдэглүүлье.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг хасаж, төслийн дугаар өөрчлөх. Санал гаргасан. Ажлын хэсэг. Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Ингэж байгаа юм. 8.8, Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар хяналт шалгалт хийгээд, шаардлагатай гэж үзвэл холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх санал, шийдвэрийн төслийг нэгдсэн хуралдаанд оруулна гэж мэргэжлийн Байнгын хороо, асуудал эрхэлсэн Байнгын хороо ажлаа хийхгүй байгаа, ажлаа Их Хурлын өмнө Их Хурлын Байнгын хорооны өмнө тайлагнадаг, тийм үү? Байгууллагуудынхаа. Одоо ажлаа сайн хийхгүй байна, ийм асуудалтай байна, ийм учраас одоо хариуцлага тооцье гэдэг юмыг өөрсдөө шууд тооцохгүй. Нэгдсэн хуралдаанд оруулах л санал. Үүнийг хасъя гээд байна. Их Хурал чинь бас бодлогоо тодорхойлно, төрийн бодлого тодорхойлно хууль батална, тэр хуулийг хэрэгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүргээ гүйцэтгэх засаг хэрэгжүүлнэ, Их Хурлын харьяа байгууллагад хэрэгжүүлнэ.

Гэтэл энд одоо алдаа дутагдал гаргадаг, ажлаа сайн хийдэггүй, хариуцлагагүй, хэнэггүй ханддаг түүнд нь асуудал ярья, хариуцлага тооцье. Ард түмний өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна, өргөсөн тангарагтаа үнэн ч биш байна. Тийм болохоор асуудал ярья гэхээр ярих эрхгүй л болох гээд байна. Үүнийг яагаад хасах гээд байгаа юм бол? Энэ уг нь байх ёстай шүү дээ. Их Хурлыг чинь үндсэндээ шүдгүй арслан гээд хэлээд байгаа шүү дээ. Эрх мэдэл алга. Тэгээд л ямар ч одоо хариуцлага тооцох юм байхгүй. Засгийн газрын гишүүдийг томилдоггүй, чөлөөлдөггүй, огцуулдаггүй болчихсон. Тийм болохоор хариуцлагын асуудлыг хөндье, оруулья гэж ингэж ярихгүй бол үндсэндээ тэгээд Их Хурал гэж томилдог ч үгүй, чөлөөлдөг ч үгүй, хариуцлага ярьдаг ч үгүй ийм байгууллага дээр жишээ нь одоо Их Хурлын нөгөө төрийн эрх барих дээд байгууллага гэдэг чадамжийн асуудал чинь байж чадахгүй. Тэр үүднээс 8.8-ыг оруулсан, одоо тэгсэн хасъя гээд л явж байх юм.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хариулья.

Ж.Сүхбаатар: Энэ дээр бол ингээд хассанаар хариуцлага хүлээлгэх боломжгүй болох тийм юм бол байхгүй байгаа. Гэхдээ энэ дээр манай Болормаа, Мөнхсайхан хоёр бас тодруулаад нэмээд хэлнэ биз. Ер нь манай төслийн бусад энэ хойд тал эд нар дээр ч байж байгаа. Байнгын хороо ч бай, Их Хурал ч бай чиглэл өгөөд хариуцлага хүлээлгэх юмыг нь харин ч тодорхой болгосон ийм заалтууд бол явж байгаа. Энэ манай тэр уялдаа холбооны үүднээс нь Болормаа ажлын хэсэг хариулах уу.

Ж.Мөнхбат: Болормаа ажлын хэсгийн микрофоныг өгөөрэй. Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн зөвлөх.

Ц.Болормаа: Сайн байна уу? Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх Болормаа.

Энэ өргөн мэдүүлсэн төсөл дээр байгаа 8.8 дахь хэсгийг яагаад хасаж байгаа вэ гэхээр 8.7-д агуулгын хувьд давхцаад байгаа учраас энэ зарчмын зөрүүтэй саналын 4 дээр байгаа Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар тогтоолын төсөл боловсруулж гэдэгт нэгдүгээрт энэ асуудал орж байгаа.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд төслийн 11 дүгээр зүйлд байгаа. Тэр 11 дүгээр зүйл дээр 11.3 дахь

хэсгийг нэмсэн, 11.2 дахь хэсгийг өөрчлөн найруулсантай холбоотойгоор энэ давхцал үүсээд байгаа гэдэг үүднээсээ ингэж найруулсан байгаа юм. Одоо зарчмын зөрүүтэй саналын 7, 8 дахь хэсэг дээр байгаа. Энэ хариуцлагын асуудал бол төслөөс хасагдаагүй.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулья.

Санал хураалт.

6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энхболд гишүүн орж ирсэн учраас төслийн 4 дүгээр зүйлийн зарчмын зөрүүтэй саналын нэгдүгээр зарчмын зөрүүтэй санал буюу төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтад дор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.2.3.терийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим гэж Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг гэж гаргасан санал байна.

Энэ дээр манай гишүүд асуулт асуусан. Тэгээд энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан Энхболд гишүүн хариулаад ингээд санал хураана. Энхболд гишүүн.

Н.Энхболд: 4.2.3. анх хуулийнхаа төсөлд ингэж томьёологдож орж ирсэн байсан юм. Төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим гэж Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ, тэгэхдээ энэ бол нөгөө хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ барих зарчим шүү дээ. Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байх, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг ойлгоно гэж. Тэгээд би энэ дээр ингэсэн юм. Үүнийг жаахан дэлгэрэнгүй болгоё гэсэн юм. Тэр дотор нь байгаа, ялангуяа гүйцэтгэх болон шүүх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг, энэ ер нь ямар ч үед барих ёстой зарчим л даа. Гэхдээ үүнийгээ арай дэлгэрэнгүй болгоё гээд тэнцлийг алдагдуулахгүй байх гэсний дараа хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын тусгайлан хуулиар тогтоосон чиг үүрэг гэж үүнийг нь оруулья гэж санал болгосон юм. Тэгээд ажлын хэсэг дээр дэмжигдсэн юм. Яагаад ингэж оруулсан юм гэхээр надад тийм болгоомжлол байгаа юм. Ер нь ч ажлын хэсэг дээр ирээд бид нар ойлголцсон.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын функц бол өөрөө маш чухал Үндсэн хуулиар олгогдсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажсан ийм зарчмууд байж байгаа. Тэгэхдээ энэ бид нарын хуучин үйл ажиллагаа явуулж ирсэн шугамаар, ялангуяа ийм хяналт шалгалтын тусгайлсан хууль гараагүй байх үед Монгол Улсын Их Хурлаас явуулж байсан зарим шалгалтуудыг, жишээ нь ажлын хэсэг байгуулаад, Түр хороо байгуулж тийм асуудал хийж байсныг би мэдэхгүй байна. Тэд тодорхой тооны гишүүд, ажлын хэсэг байгуулж байгаад бид нар ийм юмыг шалгана, тийм юмыг шалгана аа гээд. Тэгээд энэ нь сүүлдээ нарийн яривал саяын миний энэ нэмж оруулсан хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх гэх мэт бусад тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын юмыг бараг хийх гэж оролддог, эсхүл тодорхой ашиг сонирхлын үүднээс гишүүд хоорондоо тохироод ажлын хэсэг байгуулж байгаад ямар

нэг байгууллага руу шалгалт хийж очдог. Оchoод тэндээс гаргаж байгаа байр суурь, шийдвэрээ өөрсдийнхөө анхнаасаа бодсон тэр ашиг сонирхлын зөрчилтэй зүйлдээ тохируулах гэсэн ийм оролдлогууд гарч байсан. Энэ олон жилийн хугацаанд.

Тэгээд ийм юмнууд битгий гарасаай гэж бодож, гаргахгүй байх нь чухал гэж үзээд, тэгээд энэ саяын нэмж орсон энэ зүйлүүдийг зориуд нэмж оруулж бичиж байгаа юм. Тэгэхгүй бол хуулийн маань төсөл анх орж ирэхдээ мөрдөн шалгах түр хороотой, дээр нь мөрдөн шалгах арга хэрэгслээр хяналт шалгалт явуулна гэсэн ийм үг үсгүүдтэй заалтууд бас байсан. Тэгээд энэ бол өөрөө манай төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийн зарчимтай угаасаа нийлэхгүй. Тэгээд энэ юмдаа зохицуулаад зөвхөн энэ 4.2, З заалт дээр биш, бид хойшоо бас ярьж байгаад мөрдөн шалгах гэдгийгээ Улсын Их Хурлын тусгай тусгай шалгалт гэж бас өөрчилж оруулж ирсэн байгаа. Одоо санал хураахад гарч ирнэ, мөрдөн шалгах арга хэрэгслээр гэсэн үг байсан. Тэрийг бас дараа дараагийн саналуудаар ингээд хасагдаад явж байгаа. Энэ нь өөрөө нөгөө миний хэлээд байгаа, энэ тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын үүргийг Улсын Их Хурал хэрэгжүүлж байж болохгүй гэж үзэж байгаа энэ зарчимтай нийцэж байгаа гэж бодож байгаа. Тийм учраас би энэ саналыг гаргасан. Ажлын хэсэг дэмжсэн.

Хойно нь бас яг үүнтэй адилхан тайлбар өгч болох 2-3 зүйлүүдийг өөрчлөгдсөн байгаа юм.

Ж.Мөнхбат: Санал гаргагч маань саналаа тайлбарлалаа. Санал хураалт.

Бямбацогт гишүүн нэмэлт минут.

С.Бямбацогт: Яг таны одоо хэлж байгаа асуудлаар хууль санаачлагч гишүүд бид бас энэ зарчим гэдгийг хуульдаа суулгаж өгөөд төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим гэдгийг 4.1.3 дээр оруулж ирсэн. Энэ үүднээсээ яг энэ зарчмыг заавал баримтална. Үүнийг баримтлахдаа Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналтыг алдагдуулахгүй байх, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байх гэж оруулж өгсөн юм, ерөнхий оруулж өгсөн юм. Өөрөөр хэлбэл энэ үүднээсээ үндсэндээ гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэдэг дотроо таны хэлж ярьж байгаа мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тагнуул, прокурор зэрэг байгууллагууд чинь бол агуулагдчихаж байгаа.

Та бол ингээд эд нарыг тодорхой дурдаад өгчхөж байна. Яг та бидний зорилго нэг байсан. Ямар нэгэн ашиг сонирхол гаргаад ямар нэгэн байдлаар ажлын хэсэг байгуулаад тэгээд нөлөөлөх гээд оролддог. Үүнээс тусгаарлахын тулд гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг ерөнхий нь оруулсан юм. Одоо ингээд ерөнхий оруулсныг ингээд нарийвчлаад.

Ж.Мөнхбат: Бямбацогт гишүүнд нэмэлт минут өгье.

С.Бямбацогт: Бас өөр байгууллагууд тухайлбал энэ шүүхийн шинжилгээний байгууллага байж байна. Шүүхийн шинжилгээнд чинь одоо гэмт хэрэгтэй холбоотой бүхий л тийм шинжилгээнүүд хийгддэг, нотлох баримтуудыг нотолдог тийм байгууллага орхигдчихсон байгаа юм гэх мэтчилэн хайх юм бол дараа нь бас ингээд орхигдоод байж магадгүй. Тийм учраас ерөөсөө гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэх байх гээд ерөнхий утгаар нь аваад явчихвал энэ хууль маань

хэрэгжих бололцоотой энэ агуулгаар бас ойлгогдоод явчих болов уу гэдэг үүднээс л уг нь бичиж өгсэн юм.

Ж.Мөнхбат: Энхболд гишүүн хариулья.

Н.Энхболд: Би тэрийг хэлэхдээ ингэсэн шүү Бямбацогт гишүүн ээ. Хууль санаачилж оруулж ирсэн гишүүд маань ямар нэгэн тийм санаархал энд шургуулсан байна гэж үнэхээр огт бодоогүй. Түүн дээр бол санал нэг байна. Ганцхан нөгөө урьд нь хуулиуд одоо ингээд хэрэгжээд явж байхад тийм явдал гараад байсан учраас хэдийгээр одоо энэ зарчим чинь энэ хууль дээр бичигдсэн бичигдээгүй биенийхээ ажилд орохгүй гээд л байж байгаа шүү дээ. Тэгэхээр ингээд илүү тодорхой болчихвол их ойлгомжтой болчих юм болов уу гэж бодоод үзсэн.

Санал зарчим нэг байгаа. Гэхдээ ингээд дэлгэрүүлээд оруулчихгүй бол бас хэзээ нэгэн цагт өөр зүйл хүний толгойд орж ирээд жижиг ч гэсэн алдаа гарах вий дээ л гэж бодож ингэж оруулж байгаа юм. Тэгээд Байнгын хороо олонхоороо шийднэ байх. Бид нар ажлын хэсэг дээр байж байгаад уг нь энэ энэ байр суурин дээр санал нэгдээд ороод ирсэн шүү дээ.

Ж.Мөнхбат: Санал хураалт.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг түрүүний миний уншсан дор дурдсан өөрчлөн найруулахтай холбоотой зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

6 гишүүн дэмжиж 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Энхболд гишүүн цөөнх болсон.

Төслийн 9 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа юм байна.

9 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хэлбэр 9.1. Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

9.2. хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх, төсвийн хяналт, Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж, цаглабар гаргана.

9.3. төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, байгууллагын санал, гомдол, мэдээлэл, хяналт шалгалтын дүнд үндэслэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан Байнгын хорооны хяналт шалгалтын цаглабарт тусгаж хэрэгжүүлнэ.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Төслийн 10 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, Алга байна. Төслийн 11 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар” гэснийг “албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 91,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмэх:

11.3.Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Асуулт Бямбацогт гишүүн асууя. Санал хураалтыг цуцаллаа. Бямбацогт гишүүн асууя.

С.Бямбацогт: 11.3 дахь заалтыг бас дэмжиж байгаа юм. Бид нар бас эргэх холбоотой ажиллаж, төлөвлөж, тайлagnаж, гүйцэтгэлдээ хяналт тавьж, ингэж ажиллахгүй бол тэгээд л найзан нь дундаа яваад байвал тэгээд бодлого ч байхгүй, бодлого нь ч хэрэгждэггүй. Хэрэгжүүлж байгаа улсууд нь ч хэрэгжүүлэхэд тоодоггүй ийм болчоод байгаа энэ алдааг засах гэж байгаа юм. Тэгтэл дахиад л нөгөө асуудал яриад байгаа юм. Албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар тогтоол гаргана гэдэг. Албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр гээд хуульд заасны дагуу тэгээд энэ дээр нэлээн тийм мөлгөр болоод одоо юу гэдэг юм. Хуульд нь бидний бас Их Хурлын бас оролцох юм маань оролцохгүй юм байна. Тэгтэл хуульдаа тодорхой хэзээ ч халдашгүй байдалтай болчихсон байдаг. Тэгэхээр иймэрхүү юмнуудыг бас нэг жоохон бодохгүй бол, бас тэгээд хяналт шалгалт хийхийн тулд бид бас тодорхой эрх мэдэлтэй байх ёстой, хяналт шалгалт хийгээд тодорхой үр дүн гаргах ёстой. Энэ зорилгоор л энэ хуулийг санаачилж байгаа юм.

Үндсэн хуулийн зорилго ч гэсэн тийм байсан. Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүрэн эрхээсээ тодорхой хэмжээнд татгалзсан, тодорхой бүрэн эрхүүдээс татгалзсан, нөгөө талдаа бол хяналт шалгалтын бүрэн эрхээ нэмэгдүүлсэн. Энэ Үндсэн хуульчилсан хууль болж байгаа. Энэ хууль маань өнөөдөр уг нь амьдрал дээр хяналт шалгалтаа хэрэгжүүлэх ёстой, хүч чадалтай байх ёстой л доо. Гэтэл ингээд яг хариуцлага хүлээлгэх болохоор хариуцлага хүлээж чаддаггүй. Тэгсэн мөртөө баахан сүр үзүүлдэг, тэгээд нөгөө хазаж чаддаггүй. Ийм байгаад байвал хяналт шалгалт маань эхэндээ нэг сүртэй байх нь, дуутай тэнгэр хургүй, цуутай хүүхэн хуримгүй гэдэгтэй адилхан баахан л хашхирдаг сүр үзүүлдэг. Сүүлдээ ямар ч үр дүн гардаггүй болох юм бол ахиад л энэ хууль амьгүй болчихно л доо. Дахиад л Үндсэн хууль хэрэгждэг нь больчихно л доо. Тэгэхээр иймэрхүү заалтууд дээр манай ажлын хэсэг бас нэг жаахан энэ чинь төрийн эрх барих дээд байгууллага бодлогоо тодорхойлно, тодорхойлсон бодлого маань амьдрал дээр хэрэгжих ёстой. Хэрэгжүүлэхгүй байх юм бол хариуцлага ярих ёстой гэдэг өнцгөөс жаахан харж ажиллахгүй яасан юм бэ, яагаад ингээд мөлийгөөд байгаа юм бэ гэдгийг л би асуух гэж байгаа юм.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хариулья.

Ж.Сүхбаатар: Энэ талаар манай ажлын хэсэг дээр ярьсан. Энхболд гишүүн ч энэ дээр саналаа гаргасан байгаа. Улсын Их Хурал бол яг хариуцлага хүлээлгээд яг шууд шийдчих хүн нь бол яг үндсэндээ Ерөнхий сайд байгаа юм. Бусад одоо манай Их Хурлаас томилогддог хараат бус байгууллага, агентлагууд байгаа. Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо. Эд нар бол яг хуульд заасан тийм хариуцлагын хэлбэрүүд байгаа. Ийм асуудлаар хариуцлага одоо хүлээнэ ээ гээд. Үндэслэл нь бол тэндээ байж байгаа. Бусад сайд нарын асуудал ба агентлагийн дарга нар гээд явахаар яг Улсын Их Хурал бол тэр улсуудыг огцруулахгүй гээд. Ингээд шийдвэр гаргаж байгаа. Тэгэхээр хуульд заасны дагуу тэр шинэ Улсын Их Хурал өөрөө угаасаа хариуцлага хүлээлгэх асуудал Улсын Их Хурлын тогтоол гарчаж байгаа учраас тэр бол үндсэндээ одоо биелүүлж таарна л даа. Тэгэхээр мөлийлгэсэн гэхээс илүүтэй жаахан хуульд нийцүүлж л ингэж явъя гээд ингээд ажлын хэсэг дээр үүнийг хийчихсэн байгаа юм. Тэгэхгүй бол яг одоо Улсын Их Хурал дээр ингээд шууд хариуцлага одоо огцруулаа гээд ингээд юм гарахгүйгээс хойш хуульд заасны дагуу гээд ингээд явъя гэж ингэж л шийдсэн. Тэгээд Энхболд гишүүн нэмэх үү.

Ж.Мөнхбат: Санал хураалт явуулна.

Төслийн 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмэх гээд түрүүн миний уншсан саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Хууль санаачлагч маань одоо бас түрүүнээс хойш хэлээд байна шүү. Ер нь жаахан мөлийлгэх гээд байна шүү л гээд байна.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг “хүлээлгэнэ” гэснийг “хүлээлгэх үндэслэл болно” гэж өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 91,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйл дээр асуулт, санал байна уу? Алга байна.

Төслийн 14 дүгээр зүйл дээр асуулт, санал байна уу?

Шийдэгдсэн, Байнгын хорооны 27-ны хурлаар 14, 15, 16 дугаар саналуудыг хураасан.

Төслийн 17 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 18 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна. 18 дээр алга байна.

Төслийн 19 дээр алга байна.

Төслийн 20 дээр алга байна.

Төслийн 21 дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 21 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 21.5 дахь хэсэг нэмэх:

21.5.энэ хуулийн 23.4-т заасан тооцоо хийхэд шаардагдах Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг тухайн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн задаргааг зардлын эдийн засгийн ангиллаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн задаргааны хамт тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх хугацаанаас өмнөх дараалсан 3 жилийн зэрэгцүүлсэн задаргааны хамт Улсын Их Хуралд хүргүүлнэ гэсэн ажлын хэсгийн санал байна.

Асуулттай гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын хэлэлцүүлэгт бэлтгэх шатны гэснийг нэг дэх хэлэлцүүлгийг ингэж өөрчлөх. Санал гаргасан: Ажлын хэсэг.

Санал хураалт:

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийг төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт гэж хоёрын хоёрын хоёр дахь хэсгийн гаргана Улсын Их Хурлын гишүүдэд тараана гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 91,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн хэлэлцүүлэг эхлэхээс өмнөх гэснийг хэлэлцүүлгийн гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлийн мөн зүйлийн 22.4 дэх хэсгийн Улсын Их Хурал гэсний дараа нэг дэх хэлэлцүүлгээс гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 23 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 24 дүгээр зүйл асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 25 дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг хасаж, төслийн дугаар өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 26 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал.

Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсгийн 5-аас гэснийг 9-өөс гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 дэмжиж, 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 28 дугаар зүйл дээр 28.2.2 дахь заалтын 5-аас гэснийг 9-өөс гэж өөрчлөх.

Ажлын хэсгийн санал. Санал хураалт.

12 гишүүнээс 10 дэмжиж, 83,3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 27 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа юм байна.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн 5-аас гэснийг 9-өөс гэж мөн өөрчлөх.

Ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 8 дэмжиж, 66,7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгийн гарчгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 58,3 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Төслийн 29 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна. Төслийн 29 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 30 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

29 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн сонсгол.

29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон, нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна.

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, эрүү шүүлтээр урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Улсын ерөнхий аудитор, Монголбанкны ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаар томилгооны сонсгол.

9.1.2. хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол.

29.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилох, зөвшилцөл. Нэр дэвшигчийн сонсгол нь баримт мэдээлэлд үндэслэсэн талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3. нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна.

29.4. нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хуулийн нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгох бөгөөд Байнгын хорооны сонсголын сэдэв, нэр дэвшигчийн онцлогоос хамааран дэгээ өөрөө тогтоож болно.

29.5. Байнгын хорооны нэр дэвшигчийн сонсгол /цаашид “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар, мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

Санал гаргасан ажлын хэсэг. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Миний хэлсэн саналыг авсан байна л даа. Энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, дарга, гишүүн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга гишүүнийг хассан байна. Ер нь би бол тэр үндэсний олон нийтийн радио телевизийн 15 хүнийг энд оруулах хэрэг байгаа юм уу. 15 хүнтэй шүү дээ. Тэгээд Их Хурал нэг баахан болсон, болоогүй томилгооны сонсгол хийдэг болчих гээд байгаа юм. Түүний оронд энэ мэдээж Цэц, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн хороо, Төрийн албаны зөвлөл, Ерөнхий аудитор, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооныхоо юмаар ингээд л явчихвал яасан юм бэ. Энэ зөвлөлүүдийг ер нь бүгдийг нь хасчихвал яасан юм бэ гэдэг ийм саналыг би хэлсэн чинь хоёр зөвлөлийг нь хасаад, нэг зөвлөл нь ороод ирсэн байх юм.

Ж.Мөнхбат: Тогтохсүрэн гишүүн санал хэллээ.

Санал хураалт явуулна. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдэж байна

Төслийн 31, 32 дугаар зүйлийг нэгтгэн дор дурдсанаар өөрчлөн найруулах:

30 дугаар зүйл. Сонсгол даргалагч, оролцогч.

30.1. Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүнийг томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

30.1.1. сонсголын бэлтгэл хангах.

30.1.2. сонсголыг товлосон цагт эхэлбэл тогтоосон дэг сахиулах.

30.1.3. сонсголын дэг зөрчигчид хуульд заасан арга хэмжээ авах.

30.2. Сонсголд Нийтийн сонсголын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан оролцогчоос гадна нэр дэвшигч, түүний санал болгох эрх бүхий этгээд, эсвэл түүний төлөөлөл оролцно.

30.3. Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаанаар сонсголд оролцох, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.17-д заасан нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журам, хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэж үзнэ.

30.4. Байнгын хорооны гишүүн, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу нэр дэвшигчтэй хамаарал бүхий этгээд бол энэ тухайгаа сонсгол эхлэхээс өмнө нийтэд мэдэгдэх үүрэгтэй.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 31, 32 дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Би нийлүүлэн уншсан байна шүү.

Төслийн 33, 34, 35, 36, 37, 38, 39 дүгээр зүйлийг нэгтгэн дор дурссанаар өөрчлөн найруулах:

31 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн сонсголын үе шат.

31.1. сонсгол дор дурдсан үе шаттай байна:

31.1.1. нэр дэвшигчид санал болгох.

31.1.2. сонсголын тов тогтоох, зарлах.

31.1.3. сонсголын бэлтгэл хангах.

31.1.4. сонсголыг явуулах.

31.1.5. сонсголын тайлан гаргах.

31.1.6. сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах.

31.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилох, зөвшилцэх танилцуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Санал нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

31.3. хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо энэ хуулийн 31.2-т заасан саналыг Улсын Их Хурлын чуулганы хугацаанд хүлээн авсан тохиолдолд ажлын 5 өдрийн дотор чуулганы чөлөөт цагт хүлээн авсан тохиолдолд ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор дараах ажиллагаа явуулна.

31.3.1. сонсголын товыг тогтоож, нийтэд мэдээлэх.

31.3.2. энэ хуулийн 31.2-т заасан санал, нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

31.1.4. хэрэв тухайн Байнгын хороо өөрөө сонгон шалгаруулахаар хуульд заасан бол сонгон шалгаруулалтын дүн гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо энэ хуулийн 31.3-т заасан ажиллагааг хийнэ.

31.1.5. Байнгын хороо энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан ажиллагаа явуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн дотор сонсголд оролцогчдыг бүртгэх, нэр дэвшигчээс асуулт асуух, асуух, асуулт, саналыг бичгээр урьдчилан хүлээн авах бөгөөд шаардлагатай бол тухайн сонголын дэгийг боловсруулж батлах зэрэг сонголын бэлтгэлийг хангана.

31.1.6. нэр дэвшигчийн санал болгосноор сонголын үе шат эхэлнэ. Энэ хуулийн 31.1.4-т заасан сонгол явуулах хугацаа нь 3 хүртэл хоног үргэлжилж болно.

31.1.7. хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны олонх дэмжсэн тохиолдолд сонголыг хаалттай явуулж болно.

31.1.8. сонголын тайланг сонгол явуулснаас хойш ажлын 5 хоногт гаргах бөгөөд Байнгын хороонд нь танилцуулж нэгдсэн хуралдаанд тараан.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Төсөлд дор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

32 дугаар зүйл. Хяналтын сонголыг хүчинтэйд тооцох.

32.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцсоноор тухайн сонголыг хүчинтэйд тооцно.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гуравны нэгээр гэж орж ирж байгаа юм байна.

12 гишүүнээс 7 дэмжиж, 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Их Хурлын дарга.

Г.Занданшатар: Энэ сонголын процесс нэлээн дэлгэрэнгүй тодорхой байсныг ингээд хураагаад базаад тавьчихаж байна л даа. Тэгээд сая энэ нээлттэй сонголууд сая Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Сахилгын хороон дээр хийхэд бол их олон

асуудлууд гарсан шүү дээ. Ингэж, ингэж тодорхой болгох нь Мөнхсайхан докторын л санал байх. Тэгээд үүнийг ингээд хасчихаар процессоо ингэж тодорхой биш болгочихоор тэгээд үзэмжийн юмнууд их орно доо. Одоо Энхболд гишүүний яриад байдаг асуудлууд чинь. Мөнхсайхан доктор энэ дээр хасах нь зөв юм уу, та яг юу гэж харж байгаа вэ?

Ж.Мөнхбат: Мөнхсайхан доктор хариулья, ажлын хэсгийн нэгдүгээр микрофон.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд энэ хууль дээр нэр дэвшигчийн сонсголын нарийвчилсан журмыг одоо заахгүй ерөнхий зохицуулалт оруулаад энэ төсөлд байгаа нарийвчилсан харилцааг Их Хурлын тогтоолоор батлах нэр дэвшигчийн сонсголын журам дээр оруулна гэдгээр ойлголцоод тэгээд Нийтийн сонсголын хууль дээр нарийвчилсан журмыг одоо Их Хурлын тогтоолоор батална гэдгээр энэ ар талд нь санал гарчихсан явж байгаа. Тэгээд өнгөрсөн 6 сард Их Хурал нөгөө томилгооны сонсголын журмыг батлаад дараа нь Авлигатай тэмцэх газрын дэд дарга дээр сонсгол хийсэн. Тэгэхээр тэр журмыг бол шинэчлэн найруулаад энэ хуулийн төсөлд байж байгаа нарийвчилсан зохицуулалтууд тийшээ орох юм болов уу гэж ойлгож байгаа.

Миний хувьд бол хувь хүний хувьд хууль дээр заасан нь дээр гэсэн ийм байр суурьтай байсан. Гэхдээ үүнтэй адилхан агуулга журмаар зохицуулахад одоо энэ саналууд дэмжигдээд явбал журмын төсөл нь дараагийн хэлэлцүүлэг дээр бас хамт орж ирээд Их Хурлын тогтоолын төсөл өргөн баригдаад батлагдах юм болов уу гэж ойлгож байгаа. Ямар ч байсан нарийвчилсан зохицуулалтыг хийж өгөхгүй бол Их Хурлын даргын хэлсэн шиг энэ дээр бол илүү үзэмжээрээ хандах янз бүрийн асуудлууд үүсэх эрсдэлүүд байгаа. Тийм учраас олон улсын туршлага ч тэр аль болох нарийвчилсан зохицуулсан энэ журмаа одоо хууль юм уу, тогтоолоороо ингэж батлах нь зүйтэй гэдэг дээр бол санал нэг байгаа.

Ж.Мөнхбат: Мөнхсайхан докторын тайлбарыг протоколд тэмдэглүүлж байна шүү. Санал хураалт явуулна.

Санал хураалт. Ажлын хэсгийн саналаар. Төслийн 40 дүгээр зүйлийг хасах гэж байна.

Энэ санал дэмжигдсэнгүй. Төслийн 40 дүгээр зүйлийг хасах гэдэг санал.

Наад дээр чинь санал хураачихсан шүү дээ. Дэмжигдчихсэн шүү дээ.

Бямбацогт гишүүн санал гаргачих.

С.Бямбацогт: Сая санал хураалтад оролцож чадсангүй. Би уг нь дэмжиж байсан юм.

Ж.Мөнхбат: Горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүй болгох горимын санал хураалт.

12 гишүүний 7 гишүүн дэмжиж, 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 41 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасана ажлын хэсэг. Учлаарай 40-ийг хасах юм байна шүү, горимын санал дэмжигдсэн учраас.

Энэ 25, 26, 27, 28-ыг уялдуулж байгаад хасах юм байна.

12 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 41 дүгээр зүйлийг хасах гэсэн ажлын хэсгийн санал.

Санал хураалт. 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 42 дугаар зүйлийг хасах.

Санал хураалт. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 43 дугаар зүйлийг хасаж төслийн дугаарыг өөрчлөх.

Санал хураалт. Нэгдсэн чуулган дээр эд нарыг нэг санал болгон нэгтгээд оруулчих юм.

Ажлын хэсэг, Байнгын хороон дээр л зүйл бүрээр гэж байгаа биз дээ.

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 1 дүгээр дэд бүлгийн гарчгаас мөрдөн шалгах гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 44 дүгээр зүйлд зүйлийн 44.2 дахь хэсгийн мөрдөн шалгах арга хэрэгслээр гэснийг энэ хуулийн 46.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Төслийн 44 дүгээр зүйлийн 44.9 дэх хэсгийн 2 гэснийг 1 гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 44-ийн 9 дээр Энхболд гишүүн.

Н.Энхболд: Тэнд нэг асуудал нээлттэй үлдчихэж байгаа юм. Одоо жишээ нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө 6 сарын хугацаатай нэг түр хороо байгуулчихсан байж байсан чинь юмаа дуусаагүй байхад нь дараагийн юм гарад тэгэхээр тэр автоматаар татан буугддаг юмыг нь бас нэг газар суулгасан бол оруулж өгөх үү яах вэ, тэгэхгүй бол дараагийн дахин сонгогдсон хэдэн гишүүд чинь бид нар энэ түр хороонд ирсэн, одоо энийгээ үргэлжлүүлнэ гээд олонх нь байна гээд явчихвал бас эвгүй юм байгаа. Тэгэхээр Их Хурал болгоны бүрэн эрхийнх нь асуудал байх ёстой гэж л би бодоод байна л даа. Түүнийг протоколд нэг газар тусгачихвал.

Ж.Мөнхбат: Ажлын хэсэг анхаараарай. Протокол дээр тэмдэглэж байгаа юм байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр чуулган нэг парламент тийм бүрэн эрхийн хугацаа ч гэдэг юм уу нэг тийм л юм орох нь байна шүү дээ.

Төслийн 45 дугаар зүйлийн 45-ын 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно гэсэн хоёр дахь өгүүлбэр нэмэх.

Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Энэ дээр би анхнаас нь их олон үг хэлээд байсан. Нэг нь ч тусаагүй байгаа юм. Бүр дордуулчихсан байгаа юм. Нэгдүгээрт, 19 бол ях вэ? Энэ мэдээж Их Хурлын хуулиараа явж байгаа, цөөнхийн төлөөлөл олон байна гэж. Гуравны нэг гэдэг бол их өндөр байгаа юм.

Ард нь цөөнхийн төлөөлөл чинь өөрөө нөгөө нотлох баримт бүрдүүлэх эрхтэй болоод ингээд явчихсан юм.

Хоёрдугаарт, цөөнх чинь хоёр цөөнх байгаа юм. Олонх бол хамаагүй ганц л байгаа юм, цөөнх чинь дотор цөөхөн бүлэг байна, бусад гишүүд байна, энэ хоёрыг нийлүүлэх ёстой гэдэг ийм зарчмыг би хэлсэн чинь энэ ерөөсөө ороогүй байх юм. Цөөнх гэдэг дотор цөөнхийн бүлэг ороод бусад одоо бүлэгт харьялагддаггүй гишүүд орох ёстой. Ингэж гуравны нэгээ барьж явахгүй бол болохгүй. Дахиад нөгөө цөөнх гэж арван нэгээсээ долоо нь авчхаад ахиад бусад бүлэггүй гишүүд гэж ингэж аваад байх юм бол энэ бол Их Хуралд тэнцвэргүй байдал бий болох гээд цөөнхийн засаглал ч үүсэхийг үгүйсгэхгүй байдал руу орох юм.

Тийм учраас би энэ 45.2 дээр уул нь яг ийм санал хэлсэн чинь энэ нэгдүгээрт тусгагдаагүй байгаа юм. Хоёрдугаарт нэг гишүүн нэг л ажлын хэсэгт орох ёстой түр хороонд. Энэ дээр хоёрыг оруулж болно гээд орчихож байгаа юм. Тэгэхлээр бол ингээд энэ нэг чуулганы хугацаанд байгуулах Түр хороог хүртэл бид нар уул нь хязгаарлаж өгмөөр байгаа юм. Тэгэхгүй дөрвөөс таван дүр хороо гараад ирвэл ях вэ? Дөрөв таван сэдвээр. Энэ аюултай байхгүй юу? Тийм учраас бол энийг бид нар энэ 45 дугаар зүйл дээр хугацаа нэг байна гэдэг юм уу, хоёр байна гэдэг. Би ингэж одоо тоог нь хязгаарлаж өгөх хэрэгтэй байгаа юм.

Үгүй ээ, үгүй 4 жилд биш 1 бүрэн эрхийн чуулганы хугацаанд нэг байж болох л юм. Тэгэхгүй бол ингээд энэ чинь 10 түр хороо гэсэн гараад ирэх бололцоотой байхгүй юу. Тэгээд хоёр, хоёр гишүүн орно гэхээр чинь энэ чинь бүр замbaraагүй болох гээд байгаа юм. Ингээд хууль тогтоох бусад ажлууд нь орхигдоно. Тийм учраас энэ 45 дугаар зүйл дээр, нэгдүгээрт тэр цөөнхийн цөөн төлөөллийг ях вэ гэдэг асуудал. Хоёрдугаарт нэг гишүүн хоёрт ордгийг болиулах, гуравдугаарт, түр хороо байгуулах хугацааг заачихсан. Гэхдээ нэг бүрэн эрх нэг чуулганы хугацаанд хэд гарах юм гэдгийг зааж өгөхгүй бол энэ тоо томшгүй олон. Гишүүд чинь цуглаад цуглаад л. Нэг нь Оюутолгой, нэг нь Тавантолгой. Ингээд л хажуу талд нь Эрдэнэт гээд ингээд ингээд гараад ирнэ шүү дээ. Тэгэхээр хүн амины хэрэг гээд л гараад ирнэ. Тийм учраас үүнийг жаахан хязгаарлах хэрэгтэй болов уу л гэж бодоод байгаа юм.

Ж.Мөнхбат: 32 дугаар санал дээр ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хариуљяа.

Ж.Сүхбаатар: Тогтохсүрэн даргын энэ дээр бид нар нэлээн ярьсан. Тал талаас нь бодсон. Тогтохсүрэн дарга хэлж байна энэ хуульч нар ч хэлж байна шүү дээ, мөлийлгөөд байна гэж. Яг энэ хянан шалгах түр хорооны хувьд бол амин сүнс хоёр заалт байгаа. 45.2, 48,2 байгаа. Тэгэхээр та энэ хоёрыг хоёуланг нь аваад хаячих гээд. Ер нь бол адилхан байгаад байгаа юм. Энэ механизм бол ажиллахгүй юм байна билээ. Гол нь аль нэг нь тэгээд Тогтохсүрэн гишүүний тэр саналыг авахын тулд 45.2-ын цөөнхийн төлөөлөөд та яриад байна шүү дээ. Энэ цөөнхийн бүлэг юм уу? Энэ бол бүгдийг нь оруулж байгаа юм. Цөөнхийн бүлэг ч тэр цөөнх, одоо бусад нам ч бай, ингээд цөөнхийн төлөөлөл тэгж байж гуравны нэгээс доошгүй ингээд нийлээд эд нар чинь бүрдэх юм. Аль нэг хэмжээнд. Тэгээд тэр таны хэлснээс бол авсан 48.2 дээр бид нар дөрөвний нэгээс доошгүй нь гэдгийг чангаруулж гуравны нэгээс доошгүй нь болгосон. Тэгэхгүй бол бас энэ яг одоо ингээд яваад байх юм бол бойкотлоод энэ тогтоол гаргадаггүй, нотлох баримт цуглуулж болдоггүй болохоор бол энэ нэг тийм шүдгүй зүгээр нэг тийм юм болж хувирах юм байна билээ.

Тэгээд бид нар үүнийг гуравны нэгээс доошгүй гэж таны саналыг энэ 48.2 дээр авч хийж байгаа. Нөгөөдөх асуудал нь нэг гишүүн хоёроос доошгүй гэж, энэ түр хороог чинь бид нар төлөвлөгөөтэй байгуулахгүй юм байна билээ. Гэнэт шинэ ийм нөхцөл байдал үүсдэг. Тухайн чуулганы хугацаанд хоёр гурван зэрэг асуудал үүслээ гэхэд нэг гишүүн орчихдог, тэгээд дараагийнхад нь тэр орж чадахгүй бол яах вэ гэдэг оруулах шаардлага байгаад байдаг. Тэгэхээр би хоёр гэж байгаа. Иймд хэдхэн түр хороо заавал байна гэж заах шаардлага энэ бол угаасаа Улсын Их Хурал өөрөө шийдэж байгаа асуудал. Тэгээд дээр нь энэ үүсэж байгаа асуудал нь бид нар хүслээрээ хийж байгаа биш, үүссэн онцгой нөхцөл байдал дээр гаргаж байгаа түр хороо юм. Энэ түр хорооны чинь ажиллаж байгаа.

Тэгээд яг саяын тэр хэлдэг ийм гурван асуудал дээр бол ийм учир шалтгаанаар таны 48.2 дээр таны саналыг авч ерөнхийдөө тусгаад 45.2-ыг хадгалж байгаа цөөнхийн төлөөлөл гэдэг нь тэр бүх улсууд нь энэ гуравны нэгээс доошгүй нь байг гээд, энэ чинь дандаа арван есүүлээ байхгүй шүү дээ. Одоо долоон хүн байлаа гэхэд одоо ингээд л хоёр байна уу, гурав байна уу ингээд л байж байх л асуудал юм. Ихэнх нь тэгж байгуулагдахгүй нэг цөөн хүнтэй ч юм уу ингээд л байгуулгдах юм. Тийм л учиртай. Үүнийг нэлээн тийм үзэж харж, ярьж, ярьж байсан. Хэрвээ үүнийг ингэчих юм бол энэ ёстой хяналт шалгалтын тухай хуулийг чинь мөлийлгөсөн асуудалд ороод, ингээд нэг ийм худлаа хууль гаргасан хэрэгт орчих вий гэдэг ийм одоо асуудал үүсээд байгаа юм. Түүнээс биш одоо муйхарласан юм байхгүй, хууль санаачлагч чинь түрүүн асуудлууд дээр бүр хэлж байна. Тэр нь бол арай гайгүй шүү дээ, хамаагүй энэ бол харин бүр энэ төслийн бүр амин сүнстэй холбоотой. Занданшатар даргын яриад байгаа тэр мөрдөн шалгах парламентын хяналтыг хэрэгжүүлэх тэр гол нь бол юм хэт олохосоо хэт хамааралтай бас болж байна.

Энэ бол бас цөөнхийг давруулаад байгаа ч гэдэг юм уу дөвийлгээд байгаа асуудал бол бас байхгүй ийм л юм байгаа юм. Аль аль талаа бодоход бол гэж л үзээд байгаа юм. Тэгэхгүй бол энэ хороог байгуулаад одоо бараг яах уу л болчоод байгаа юм л даа. Яг тэр саналаар чинь найруулчхаад ингээд л буулгачих юм бол тэгэхээр нэгэнт ингээд ажиллахгүй юм бол энэ хороог чинь одоо энд тусгана гэхээр чинь ингээд болохгүй болчоод байгаа юм. Тийм л утгаар л одоо үүнийг хийсэн юм.

Ажлын хэсгийн ахлагч, хууль санаачлагч Бямбацогт гишүүн нэмж хариулья.

С.Бямбацогт: Энэ бас чухал асуудал хөндөж байгаа юм. Ажлын хэсэг бас нэлээн харсан байна гэж хэлэх гээд байгаа юм. Би 45.1 дээр түр хороо 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байна гээд. Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд ажиллаж болно гэж. Хэрвээ ийм өгүүлбэр орохгүй бол Их Хурлын гишүүн таван ч юм уу хянан шалгах түр хороонд орох бололцоотой болчих гээд байгаа юм. Тийм болохоор хоёроос илүүгүй гэдгээрээ үндсэндээ бол дээд талд нь тааз тогтоож хязгаарлаж өгч байна. Тэгэхгүй бол маш олон хянан шалгах хороо байгуулаад л тэгээд одоо бүгдэд ороод л явж байдаг тийм болчих гээд байна. Тийм болохоор хоёроос илүүгүй хязгаарлалт өгч байгаа юм бол ажлын хэсгийн саналыг би бас тодорхой хязгаарлаж, тааз тогтоож байгаа нь зөв байна гэж бодож бүрэн эрхийн хугацаанд одоо юу гэдэг юм тэд л байх ёстой гээд. Ингэх юм бол амьдрал баян. Ямар ч асуудал хэзээ ч гарч болно. Хэлж болзошгүй асуудлууд тэр болгон дээр одоо юу гэдэг юм, бид хуулиараа ерөөсөө энэ бүрэн эрхийн дөрвөн жилийн хугацаанд ерөөсөө дөрвөн удаа л түр хороо байгуулах эрхтэй. Одоо бидний эрх дуусчихсан, тэгээд Үндсэн хуульд чинь Монгол Улс төрийн эрх барих дээд байгууллага, тийм үү? Гадаад, дотоод төрийн бодлого аль ч асуудлыг санаачилгаар хэлэлцэх эрхтэй. Гэтэл одоо бидний бүрэн эрх дуусчихсан шүү дээ. Дөрвөн жилийн хугацаанд дөрвөн удаа л түр хороо байгуулах ёстой байсан. Одоо бол бололцоо алга гэж болохгүй.

Ингээд үндсэндээ бол дээд таазыг нь тогтоох бөгөөд доод талд нь амьдрал баян юм чинь амьдрал дээр тулгамдсан асуудлаар зайлшгүй шаардлагатай бол Их Хурал олонхороо шийдээд явна шүү дээ. Ийм байдлаар шийдэх үндсэндээ бол Их Хурлын олонхын бодлого энд явна гэдэг талаас нь бас ойлгох ёстой байх.

Дараагийн асуудал дээр цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлнэ гээд, Өөрөөр хэлбэл бас дахиад дээд тааз өгч байгаа. Цөөнх Их Хурлын 76-гийн хэд байна түүнээс хэтэрч болохгүй шүү гэдгээр нь. Нөгөө талдаа энэ дээр бичсэн гуравны нэгээс доошгүй нь гэдгээр. Бас нэг хэтэрхий олонх түрж болохгүй шүү гээд доод шалыг нь тогтоод өгчхөж байгаа юм. Энэ коридорт л байх ёстой шүү. Хамгийн доод тал нь гуравны нэг байх ёстой шүү. Хамгийн дээд тал нь хувь тэнцэх ёстой шүү. Хэрвээ одоо 40:60 байх юм бол 40:60- аас илүүгүй байх ёстой. Хэрвээ 20, 80-тай байвал 33-аас доошгүй байх ёстой. Ийм байдлаар л үндсэндээ бол шал, тааз хоёр тогтоож энэ коридор үүсгэж, үндсэндээ цөөнхийн төлөөлөлтэй ардчилал байх ёстой гэдэг үүднээс л үүнийг оруулж ирж байгаа юм. Үүнийг бас гишүүд маань зөв ойлгоорой, тэгээд цөөнх гэдэгтээ бол олонхоос бусад цөөнхийн бүлэг, ардчилсан намын бүлэг одоо юу гэдэг юм, XYH намын бүлэг гээд ингэх юм бол бүгдээрээ гуравны нэг орно гэсэн үг биш. Ингээд жаран зургаан хувь болчихно гэсэн үг биш. Ерөөсөө тэр одоо байж байгаа бүх цөөнхүүд олонхоос бусад нь бүгд нийлж байгаад л гуравны нэгээс илүүгүй байх ёстой. Энэ л утгаар нь ойлгох ёстой.

Ж.Мөнхбат: Одоо Тогтохсүрэн гишүүн нэмж асууна. Тэрний өмнө би бас нэг юм хэлчихье. Сая Бямбацогт гишүүний ярьж байгаа нэг ийм асуудал үүсчихээд байгаа юм. Жишээлбэл аль ч нам олонх болоогүй бол яах вэ? 30 суудалтай, цаана нь 4-5 нам 8, 9, 10 хүнтэй бүлэгтэй, зарим нь бүлэггүй ч юм уу ийм цөөнх байлаа гэж бодъё. Тэгвэл наадах чинь цөөнхийн нь хувь тэнцүүлнэ гэхээр цөөнхийн бүлгүүдтэй нэмээд явбал олонх нь болчих гээд байгаа юм. 2-3 бүлэг байна гэвэл бүлгүүдийг, түүнийгээ сая Бямбацогт гишүүний ярьж байгаа шиг тодорхой зааж өгөхгүй бол бүлэг бүрээс гуравны нэг гээд явбал наадах чинь асуудал үүснэ шүү дээ. Тийм ээ.

Тогтохсүрэн гишүүн нэмж асууя. Миний санааг ажлын хэсгийн гишүүн давхар хариулчхаарай.

Д.Тогтохсүрэн: Одоо орж ирж байгаа санал буюу 32 дахь саналыг Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд дөрвөн жилийн хугацаанд нэг хүн хоёр л ажлын хэсэгт орно гэж ойлговол болох юм байгаа юм. Би тэгж ойлголоо. Харин 45.3-ыг тодруулж бичиж янзлах ёстой юм. Саяын Мөнхбат гишүүн бид хоёрын хэлээд байгаа санал дээр. Парламентад дөрвөн нам орчихсон байя гэж бодъё. Нэг нь гучин суудалтай олон суудал авчихсан. Энэ тохиолдолд негөө гурвын төлөөлөл өндөр болчих гээд байгаа юм.

Негөө талаар хоёр дахь заалт дээрээ нам, эвслийн бүлэгт ороогүй нөхөр яах вэ гэхээр тав ч юм уу, зургаан ч юм уу, долоон гишүүнтэй нам, эвслийн бүтлэгт ороогүй нөхдүүд чинь тэр цөөхөн бүлэг рүү очиж орох ёстой юм. Цөөнхийн хэсэг рүүгээ үүнийг нь 45.3 дээр их тодорхой болгож бичих ёстой. Энэ яваандаа 45.3 маргаан үүсгэж байна. Нэг дэх нь бол ганцхан өгүүлбэр байгаа юм. Хувь тэнцүүлнэ гээд энэ болж байгаа юм. Гэтэл 45.3-аараа үүнийхээ процессыг бичихдээ үүнд тодруулга хийж өгөх хэрэгтэй байгаа юм. Үүнийг юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр ажлын хэсэг дахиж, ерөнхийд нь бол дэмжихээд 45.3-ыг Мөнхсайхан нар ч байна. Нэг ярьж байгаад тэнцүү суудалтай парламент бурдчихсэн тохиолдолд хамгийн гол зүйл энэ үед л энэ хяналт шалгалтын хуулийг их ярина шүү дээ. Тийм учраас энэ үед яаж авч явах вэ гэдгийг л их сайн бодож энэ дээр нэг жаахан процессын юм л оруулмаар байгаа юм.

Ж.Мөнхбат: Энхболд гишүүн үг хэлье.

Н.Энхболд: Энэ 45.3 дээр бас нэг ийм заалт байгаа юм. Нам, эвслийн бүлэгт харьяалалгүй гишүүн түр хорооны бүрэлдэхүүнд орох хүсэлтээ Байнгын хороонд хүргүүлнэ гэж. Байнгын хороо энэ ирүүлсэн нэрийг өөрчлөхгүй гэж байгаа юм. Тэгэхээр одоо жишээ нь 7 хүнтэй нэг нам байя, бүлэггүй. 7 хүнтэй, гурван нам байя гэж бодъё, 21 хүн болчихно. Тийм ээ, бид нар нэрээ ирүүлчихлээ. Үүнийг өөрчлөхгүй. Хуульд заасан 21-лээ орно гэвэл негөө 19 сая хэтрээд ингээд явж байгаа юм. Тэгэхээр энэ энийгээ бид нар бас өөрчлөхгүй бол болохгүй юм байна. Эсхүл тэр ирүүлсэн нэр дотроос нь дээд хязгаартаа багтаад хувь тэнцүүлсэн зарчимдаа нийцүүлээд аль нэгийг нь авна гэдэг ч юм уу. Тийм ээ, тэр тоогоор нь сонгож авна гэж оруулахгүй бол дахиад би тодруулаад хэлэхэд жишээ нь 7 хүнтэй гурван нам байхад бүлэггүй мөртөө бүгд нэрээ ирүүлчхээд хууль дээр энэ нэрийг өөрчлөхгүй, тэгэхээр бид нэрээ өөрчлөхгүй гээд хуульд заачихсан гээд ингээд байвал бас асуудал үүсэх юм байгаа.

Тэгэхээр энэ бүрэлдэхүүнийх нь хэсэг дээр нэг зүйлийг хэдүүлээ их зөв найруулахгүй бол дараа нь энэ дээр ойлгомжгүй байдал үүсэх байх гэж бодож байна.

45.2 дээр, цөөнхийн төлөөлөл гэдэг дээрээ харин негөө бие даагч гэж нэмж хэлж өгөх үү, эсхүл ерөөсөө л хамгийн олон суудалтай нь олонх, бусад нь нийлээд цөөнх гэж үзнэ гэвэл бас Мөнхбат даргын ярьсан шиг тийм нөхцөл байдал үүсч магадгүй байх. Тэгээд энэ хоёр заалт дээр бид нар их анхааралтай хандаж байж хийхгүй бол болохгүй.

Хамгийн сүүлд нь энэ сая Тогтохсүрэн даргын хэлснээр үүнийгээ хэдүүлээ ярьж байгаад л больё. Нэг гишүүн бүрэн эрхийн хугацаанд хоёроос илүүгүйд орно гэх үү, чуулганы хугацаанд гэх үү гэдгийгээ бас бодолцох хэрэгтэй. Би юун түрүүнд бас

зарим гишүүд ч хэлээд байна. Юунаас жаахан санаа зовоод байгаа вэ гэхээр янз бүрийн шалтгаанаар энэ тусгай шалгалт гээд түрүүн мөрдөн шалгах хороо гэж явж байсан. Түр хороо түүнийгээ бид нар тусгай шалгалтын ч гэдэг юм уу ингээд нэрлэж байгаа. Ямар ч асуудлыг онцгой болгож харуулж болно. Тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулаад. Бид нар одоо ингээд ярихдаа тухайн үед үүссэн ноцтой асуудлуудыг л хэлэлцэнэ үү гэхээс ингээд байн байн гарад байхгүй шүү дээ гэж ингэж явна.

Гэтэл өдөр тутам гарч байгаа асуудлыг бүгдийг нь ноцтой, онцгой гэж үзээд баахан шуугиан дэгдээгээд асуудал болгоноор ийм хороо гаргаад, ажлын хэсэг гаргаад л байвал миний ерөөсөө гол санаа зовж байгаа юм нь тэр л дээ. Хууль тогтоох үндсэн ажилдаа оруулж чадахгүй зогсоо зайгүй улс төрждөг, асуудал болгоныг онцгой болгож харагдуулаад л сэвээд л, тэгээд гарцаагүй байдалд оруулаад л ингээд нэг их олон баахан шалгалт хийдэг улс төрждөг, улс төржүүлдэг ийм бүтцүүд бий болчих вий дээ л гэж санаа зовоод байгаа юм. Тэр бид нарын амьдралд зэндөө тохиолдож байсан туршлага шүү дээ. Түүнээс биш одоо бусдаар нь ингээд энэ нэг хяналт шалгалтынхаа ажлыг аль болохоор мохоох, зөвлүүлэх гээд байгаа асуудал огт байхгүй шүү. Үүнийг манай гишүүд маань их зөв ойлгоорой, тэгээд зовлонг нь бас ингээд бид нар бүгдээрээ хамт туулаад ирсэн болохоор л үндсэндээ Их Хурал дээр ямар ч асуудлыг онцгой асуудал болгож харуулж болно. З өдөр хэрэлдээд л нэг жижигхэн асуудлыг ялаа шиг асуудлыг зайлшгүй болгож байгаад тэгээд явчихна гээд байвал дараа нь Их Хурлын маань ажилд бас сөрөг нөлөө үзүүлчих вий дээ гэж би санаа зовоод байна. Түрүү, түрүүчийн саналуудыг ч гэсэн тэгж гаргасан юм шүү.

Тэгэхээр энэ 45.2, 45.3 дээрээ хэдүүлээ их зөв томьёолол олоод гарч болох хувилбаруудыг бүгдийг нь тооцож байгаад ийм л байдлаар томьёолбол маргаангуй болох юм байна гэдэг дээрээ дахиад бид нар ажлын хэсэг ч ажиллаж. Хууль санаачлагч настайгаа ч гэсэн бас санал солилцож байгаад энэ дээр ажиллаж болох байх гэж бодож байна.

Ж.Мөнхбат: Занданшатар дарга үг хэлнэ. Баатарбилэг гишүүн үг хэлнэ. Би нэг зүйлийг Энхболд гишүүний хэлсэнтэй холбогдуулаад хэлэхэд, жишээлбэл 12-20 бие даагч ороод ирвэл яах вэ? Наадах чинь олонх болчихно. Түүнийг нь 10-12 гишүүн бол байнга одоо түр хороо байгуулаад байж болох нь байна шүү дээ.

Цөөнхөөс бол 6-7 хүн олдоно шүү дээ. Ямар ч сэдвээр. Тэгэхээр 12 гишүүн нэгдээд л нэг нэг түр хороо байгуулчихвал бие биеийнх рүүгээ нөхөж ороод ингээд яваад байх нөхцөл байдал үүсчих вий. Тэгэхээр үүнийгээ бас бүгдээрээ сайн бodoх хэрэгтэй.

Их Хурлын дарга үг хэлнэ.

Г.Занданшатар: Тэгээд энэ гишүүд үүнийг анхааралтай нэг сууриа ойлгох ч байгаа Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1-д сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлгийг Улсын Их Хурал дахь олонх гэнэ. Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцэнэ. Ийнхүү зөвшилцэж чадаагүй Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцэн Үндсэн хуулийн 39.2-т заасны дагуу олонхыг бүрдүүлнэ. 11.1, 11.2-т зааснаас бусад Улсын Их Хурал дахь нам,

эвслийн бүлэг, бас гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх нь гэж, тэгээд 7 суудалтай, 7 гишүүнтэй хэдэн ч нам байлаа гэсэн гишүүн гэж тооцогдоно. 5 ч байлаа ч гэсэн бүгд нийлээд цөөнх гэж үздэг.

Өөрөөр хэлбэл 5 ч нам бай, 6 ч нам бай гишүүн дан гишүүн ч байлаа гэсэн тэгэхээр цөөнхөөс бүрдэнэ гэдгийг үүнийгээ цөөнхийн төлөөлөл байна гэдэг шиг бүгдийг нь, нийт массаар нь тэр гурвын нэгээс хэтрэхгүй гэдэг энэ агуулгаараа ойлгож Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулийн тэр агуулгаараа олонх, цөөнхийн томьёоллоо бол, хэрвээ энэ ойлгомжгүй гишүүд ойлгомжгүй байгаад байх юм бол Улсын Их Хурлын хуулийн 11.1, 11.2, 11.3-ыг ишлээд, гишүүдээ ойлгомжгүй байгаа бол тэгээд хийчихэд ер нь илүү тодорхой болчихно. Тэгээд энэ хуулийг тэгж тодорхой хийхгүй, энэ процессыг ингэж заахгүй болохоор энэ 44.10 дээр хяналт шалгалтын түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг маргаан хялан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно гэж байгаа юм. 44.10 дээр. Ийм хаалтууд бол нэлээн хэдэн газрууд дээр 44.7-д заасны дагуу Энхболд гишүүний санаа зовоод байгаа жишээлбэл тийм асуудлууд гарвал мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг Үндсэн хуульд харшилсан гэж өөрчилсөн нь үндэслэлгүй гэж үзвэл түр хороо байгуулах санал гаргасан гишүүд Улсын Их Хурлын тухай тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж болно. Бас үндэслэлгүйгээр ингэж гаргавал Үндсэн хуулийн цэцэд гаргаж болно гэдэг чинь нөгөө хяналт тэмцлээрээ, бас Үндсэн хуулиас давсан эрх мэдэл шүүх болон Үндсэн хуулийн хяналт тэнцэлд сөрөг учруулахгүй байх бүх юмыг процессын хуулиараа л хязгаарлаад бүх юмнуудаа сайн хийж байх нь зүйтэй юм шиг байгаа юм.

Тэгээд тэр дотроо энэ саяынх бол тэр олонх, цөөнх гэдэг яг тэр томьёоллоор хийгээд Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1, 11.2, Үндсэн хуулийн 37-д байдаг билүү? 38, 39 ч байна уу, тэд нараас ишлээд тодорхой болгохгүй бол тийм ойлголт сүүлд нь гараад маргалдаад байвал тодорхой процессыг нь зааж өгье.

Ж.Мөнхбат: Баатарбилэг гишүүн саналаа хэлчихье.

Ё.Баатарбилэг: Тэгээд нэгтгээд ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүн бид нар үүнийг ажлын хэсэг дээр нэлээн ярьсан юм. Тэгээд сая Занданшатар даргын ярьж байгаатай санал нэг байгаа, тэгж ойлгоод явж байгаа юм. Энэ дээр сая Энхболд дарга, Тогтохсүрэн дарга нарын ярьж байгаагаар бол нөгөө олонх буюу одоо гучин есөөс дээш суудал авахгүй бол яах вэ гэдэг томьёолол дээр олон суудалтай гэдгийг юу гэж ойлгох вэ? Түүнээс хувь тэнцүүлнэ гэж байгаа учраас ерөөсөө л хамгийн олон суудалтай нь тэр дотроо хувь тэнцүүлээд л хяналт шалгалтынхаа хороонд олонх нь болоод явна шүү дээ. Бүрэлдэхүүнд нь. Нөгөө талаараа түрүүн тэр одоо яг энэ санал хураалгах гээд байгаа томьёолол дээр тэр хоёроос илүүгүй гээд нэг гишүүн гээд за яах вэ, тэр сунгах хугацаагаа хоёр удаа гэж байсныг нэг удаа сунгахаар болчихлоо шүү дээ. Түр хороо. Энэ дээр хэтэрхий бас бүрэн эрхийн чуулганы хугацаанд гэдэг юм уу ингэж ормооргүй байгаад байгаа юм.

Одоо уг нь үүгээрээ л явчихмаар байх юм. Бид нар жаахан мөлийлгөх гээд л байгаа харагдаад байна түрүүнээс хойш. 19 гишүүн түр хороо байгуулна шүү дээ. Тэгэхээр тэр болгон дээр одоо ингээд амьдрал баян гээд л 19 гишүүн нэгдээд л түр хороо байгуулаад байж чадах уу, үгүй юу. Тийм олон түр хороо гараад байж чадах уу, үгүй юу. Тэгэхээр бид нар бол одоо үүгээрээ л явчихмаар байна.

Ж.Мөнхбат: Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Занданшатар даргын хэлээд байгаагаар бол уг нь ойлгох хэрэгтэй байгаа юм. Ер нь бол нарийн яривал олонх, цөөнх гэж бол заавал гарна шүү дээ. Олонх гэж бол. Үндсэн хуульд зааснаараа олонхыг бүрдүүлж байж Ерөнхий сайдын томилж, тэр Засгийн газрын чинь ард тал нь бий болно шүү дээ. Олонхыг бий болгоно шүү дээ. Тэгэхээр олонх гэдэг бол Үндсэн хуулийн агуулгаараа бол заавал гарна. Цөөнх бүлгүүд байсан ч гэсэн нийлж байгаад л олонхыг бүрдүүлнэ. Нэг логик нь нөгөөдөхийг нь бүр болилоо гэж бодоход энэ 45.2 дээр чинь Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулна гэж байгаа шүү дээ. Зарчмуудыг заачихсан байгаа. Бүр аргаа барвал энэ нам, эвслийн төлөөллийг оролцуулна. Яагаад вэ 45.3 дээр Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүй гэдэг чинь буруутай биш шүү дээ. 44.6 дээр Байнгын хороо түр хорооны гишүүдийн томилох саналыг гаргана гэхээр нэрийг нь өөрчлөхгүйгээр тэнд байгаа хүмүүс чинь саналаа хураагаад л Улсын Их Хурал байгуулна шүү дээ. Тэр өрсөлдөж болно шүү дээ. Түр хороонд ороод зарим нь хасагдана. Энэ чинь унана шүү дээ. Зарим нь бол дэмжлэг авахгүй, энэ нөхрийг оруулахгүй гээд. Тэгээд энэ механизмаараа дотоод агуулгаараа ингээд 45.3, 45.2, 44.6. Тэгээд түр хороог байгуулж байгаа тэр 44.1 эд нар чинь ингээд нийлэхээрээ комплексн ийм юм уншигдаад л байна.

Тэгэхдээ 45.3 дээр заавал юм юм нь арай тодорхой биш бол, гэхдээ тэр агуулга нь тийм байгаа юм. Алдаатай болчихсон юм бол байхгүй. Байнгын хороо угаасаа нэрийг нь өөрчлөх нь буруу шүү дээ. Хүсэлтээ өглөө, Байнгын хороо санал хураалаа, томилох саналаа Улсын Их Хуралд орууллаа. Улсын Их Хурал санал хураагаад тэр хэдэн хүнийг чинь томилж, тэгээд энэ чинь 19-өөс доошгүй гишүүн энэ саналыг чинь гаргана шүү дээ. Түр хороо гэж байна, 19-өөс доошгүй. Ирүүлсэн нэрийг нь оруулаад л Байнгын хороо хэлэлцэх ёстой. Байнгын хороо хэлэлцээд л хүн нь нэг бүрчлэн ч юм уу. Тэгээд ингээд л явах ёстой. Тэгэхээр Улсын Их Хурал үүнийг чинь байгуулна шүү дээ. Тэгээд энэ дотроос чинь зарим нь орохгүй тэгээд Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг чинь тэгээд нэг ийм Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүд нэг юмаа уялдаа холбоог нь хангаад явчих нь энэ дотор байгаа шүү дээ. Ингээд өөрсдөө саналаа өгөөд энэ чинь шийдэгдэнэ шүү дээ. Түүнээс биш яг үүнийг одоо ингээд процессыг нь бичнэ гэвэл 7 хүнтэй байвал яах вэ? 5 нам гараад ирвэл яах вэ гээд бодоод явлаа гэхэд энэ нэг заалт жишигэлбэл түүнд хариулт өгч чадахгүй байна гэж бодохгүй байх юм алга. Гэхдээ 45.3 дээр энэ төслөөс илүү сайн, нарийвчилсан, уялдаа холбоо хангасан заалт байвал ажлын хэсэг авч үзэж болж байна.

Гэхдээ хоорондоо заалтууд нь уялдаад байгаа юм. Ганцхан олонхын бүлэггүй бол яах юм бэ гэдэг нь энд 45.2 дээр ч гэсэн байж л байгаа. Нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулна, суурь юмаа баривал олонхыг бүрдүүлж байгаа намууд Ерөнхий сайдыг томилохдоо нийлж нэгдсэн тэр олонхыг бүрдүүлсэн намууд чинь олонх болоод тэгээд үлдсэнийг нь цөөнх гэж тооцоод пропорцлоод явж байна шүү дээ. Тэгээд сул байгаа улсууд Байнгын хороон дээрээ нэрээ өгчихсөн хүмүүсийг нь аваад ингээд л саналаа гаргачихна. 42.3, 42.4. Тэгэхээр ингээд хоорондоо уялдаад байгаа юм. Гишүүд ингээд Улсын Их Хурал шийднэ, Байнгын хороо нь саналаа хураана.

Ж.Мөнхбат: Гишүүд үг хэлж, асуулт асууж хариулт авч дууссан.

Одоо 45.1-ээр санал хураана.

45.3 дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ.

Энэ 45, 48 хоёрыг бол манайхан одоо маш сайн бодох хэрэгтэй шүү. Бид нар ёстой нөгөө долоо хэмжиж нэг огтолж байж л үүнийг хийхгүй бол сүүлдээ одоо янз янзын нөхцөл байдал үүсэх, жишээлбэл 19 хүртэлх гишүүн түр хороо байгуулж болно тийм үү? Хяналт шалгалтын хуулиар 19-өөс доошгүй, 19.

Тэгэхээр гуравны нэгээс доошгүй нь цөөнх байна гэвэл 6, 7 хүн орж ирэх нь ээ. Тэгэхээр 12 гишүүн бол парламентын бүрэн эрхийн хугацаанд арван хоёр түр хороо байгуулж болохоор болж байгаа. Нэгдээд. Нэг нь нэг түр хороо байгуулаад л, нөгөөдүүл нь дэмжээд л тэртээ тэргүй цөөнх бол орж ирээд байх учраас. Тэгэхээр үүнийг бас цаашдаа тийм нөхцөл байдал үүсэхээс болгоомжлох хэрэгтэй.

Ингээд цаашдаа Их Хурал бол мэдээж тийм зүйл дээр дэмжээд л явна шүү дээ. Одоо зарим зарчмын асуудал ороод ирж байгаа үед бол 19 нөхөр хэвлэлийн хурал хийгээд л энэ ёстой болохoo байлаа гээд л 19 өдөр дараалаад л хэвлэлийн мэдэгдэл хийхэд үнэхээр л тийм юм байх даа л гэх бодох нөхцөл байдал үүснэ гэдгийг бодох хэрэгтэй.

Ингээд 45.1-ийг ажлын хэсгийн оруулж ирсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

12 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.3 дээр Тогтохсүрэн гишүүн санал гаргана.

Д.Тогтохсүрэн: Би ийм томьёолол бэлдчихлээ ажлын хэсэг, энэ болохгүй байгаа заалт нь ийм хоёр заалт байгаа. 45.3 дээр. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг гэдэг нь болохгүй байгаа юм. Хоёр дахь юм нь юу байна вэ гэхээр нам, эвслийн бүлэгт харьялалгүй байгаа гишүүн орж болно гэдэг нь буруу байгаа юм. Тэгээд би энэ хоёуланг нь хасаад ингээд орчихвол яасан юм. 45-ынхаа хоёрыг л бид нар ингээд ойлгочихлоо шүү дээ. Олонх гэдэг бол гучин есөөс дээш. Тэртээ тэргүй Үндсэн хуулиараа олонх болохын тулд 39-өөс дээшээ л бүрдүүлж таарна шүү дээ. Олонх болсон нөхөр нь. Цөөнх гэдэг нь бусад нь гэж ойлгоод 45.3 дээр ямар юм оруулах гэж байгаа гэхээр 45.3-ыг ингэж өөрчилье гэсэн юм. Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 45.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэн шийдвэрлэнэ. Нэр өөрчлөхгүй байх ёстой. Тэгэхгүй бол цөөхөн хэдийгээ унагаж байна шүү дээ. Энэ чинь тийм. Тийм учраас нэр өөрчлөхгүй байх ёстой. Тэгэхээр цөөнх болсон нөхөр яах вэ гэхээр 39-өөс доош суудал авсан намууд, бүлгүүд нийлж байгаад 30 суудалтай байх юм. Болбол түүндээ тохирох хүнээ 2-3-уулаа нийлүүлж оруулж ирнэ гэдэг ийм л зарчим үүний цаана харагдах болов уу. Нам, эвслийн бүлэг гээд нэрлэчихээр чинь болохоо байчхаад байх юм. бие даагч чинь цөөнх дотроо л орно.

Ж.Мөнхбат: Нэг бүрчлэн санал хураана гэдэг юм чинь хаана яваа билээ?

Д.Тогтохсүрэн: Байнгын хороо шийднэ гэж алга байна шүү дээ. Тэгэхээр иймэрхүү томьёоллоор оруулбал ясан юм бэ? Олонх гэдэг дотор гучин есөөс дээш цөөнх гэдэг дотор бусад нь. Тэгэхгүй болохоор нөгөө нам, эвслийн бүлгийн нэр заагаад эхлэхээрээ нөгөө нэрс ирээд тэгээд нөгөө хүн нэг бүрчлэн санал хураана гээд байгаа.

Ж.Мөнхбат: Тогтохсүрэн гишүүний 45.3 дээр гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

11 гишүүнээс 9 дэмжиж, 81.8 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Төслийн 45 дугаар зүйл дээр санал асуулт, ажлын хэсгийнх байна.

Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.9 дэх заалтын “газар дээр нь очиж үзэх” гэсний дараа “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт

11 гишүүнээс 10 дэмжиж, 90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 46 дугаар зүйлийн 46.11 дэх заалтын “тайлан” гэсний дараа “санал дүгнэлт” гэж нэмэх.

Санал хураалт.

11 гишүүнээс 9 дэмжиж, 81.8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 46 дугаар зургаадугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын “үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах” гэснийг “үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд холбогдох баримтыг хүргүүлэх” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт. 35 дугаар саналыг хэлж байна.

11 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 47 дээр санал, асуулт алга.

Төслийн 48 дээр байна. 48 дугаар зүйлийн 48.2, 48.3, 48.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

48.2. түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахтай холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны тогтоол гарсанд тооцно.

Ажлын хэсгийн санал байна. Тогтохсүрэн гишүүн үг хэлэх үү, асуулт.

Д.Тогтохсүрэн: Одоо нөгөө цөөнхөд чинь бүх эрх мэдэл ингээд цөөнхөд очиж байгаа заалт байгаа юм. 48.2 уг нь одоо үүгээр олонх нь л гэж оруулмаар байгаа юм. Тэгэхгүй бол түрүүний гуравны нэг гэдгээр чинь тэгээд 7 гишүүн санал гаргаад л яваад байна шүү дээ. Бүх юмыг. Тэрийг гэрчээр дуудна, тэрийг байцаалт авна, ийм шинжээч томилно, одоо нотлох баримт бүрдчихлээ гээд л нэг улс төрийн шинжтэй юм

л хийгээд байна шүү дээ. Тэгээд энэ чинь нөгөө улс төрийн хороо болчих гээд байгаа юм. Улс төрийн хороо болох заалт нь энэ 48.2 байгаа юм. Бид нар хэд хэдэн түр хороо байгуулж байсан. Үр дүн гараагүй шүү дээ. Дарга нь юм уу, хэн нэгэн нөхөр нь тэгж улс төр хийсээр байгаад л дараагийн сонгуулийнхаа улс төрийн нөхцөлийн суурийг тавьдаг.

Үүнийг одоо энэ босгыг өндөрсгөж өгөх ёстой. Гуравны хоёр болохгүй олонх л гэмээр байгаа юм. Яах вэ, ингэж ингэж болно. Санал нь бол цөөнх гуравны нэг нь гаргаад түүнийг олонх дэмжсэн тохиолдолд окей гэж ингэж л болох байхгүй юу. Тэгэхгүй олонхын шийдвэрлгүй гуравны нэгийн шийдвэрээр юм яваад байдаг болчих гээд байгаа юм.

Ж.Мөнхбат: Би бас Тогтохсүрэн гишүүний гаргасан санал дээр давхар бас нэг санал хэлчихье. Бид нар энэ 19-өөс доошгүй гишүүнтэй хороо байгуулчихлаа 19-ийн гуравны нэг гэдэг чинь 7 нь цөөнхөөс орж байгаа юм. Тэгээд гуравны нэгээр одоо ийм чухал юмыг хийлгэнэ гэдэг чинь тэр 7 хүн нэгдээд л хийхээр болчож байгаа юм. Тэрийг ойлгочихсон тийм ээ. Цаана нь олонхын бүлгээс гуравхан хүн цөөнхтэй нийлэхэд 10 шүү дээ. 19- өөс 10 гэхээр чинь 7 дээр 3-хан хүн нийлээд ингээд л одоо цөөнх бол тэртээ тэргүй дэмжих нь ойлгомжтой. Ингээд л юм явах нь байна шүү. Үүнийг гуравны хоёр гэж тавьж өгмөөр л байна.

Ажлын хэсгийн ахлагч.

Ж.Сүхбаатар: Энэ чинь эндээс яагаад хасагдаж байгаа юм бэ гэхээр төслийн хууль санаачлагчийнхаар хянан шалгагч томилох, газар дээр нь очиж үзэх бичиг баримт, дүн шинжилгээ хийх гэчихсэн энэ хэсгүүд нь хасагдаж байгаа юм. Энэ түр хороо гээд парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны чинь түр хорооны гол амин сүнс юу байдаг юм гэхээр бас цөөнхийн оролцоо байдаг. Цөөнх эрх мэдлийг давуулж байгаа юм. Угаасаа бусад улс орнуудад ч тийм л байдаг, хэрвээ олонх гэчихвэл олонх гэрчээр хэнийг ч дуудахгүй, дуудлаа гэхэд байна шүү дээ тэр шинжээч томилох гацаах бололцоотой. Тэгэхээр тэр түр хороо чинь угаасаа гэрч нь дуудагдахгүй, нотлох баримт гаргуулахтай холбоотой асуудал ажиллахгүй болохоор энэ түр хороо чинь угаасаа ажиллахгүй. Түр хороо чинь олонхынхоо тулд ганцхан бас оршин тогтнож байгаа биш. Тэгээд анхнаасаа энэ хянан шалгах түр хороог энэ Үндсэн хуульд заах хэрэггүй байсан, гол нь тэгэхгүй. Энэ яг ингээд логикоор нь одоо ингээд бодчихвол энэ асуудал нь цаанаа ажиллахгүй болчих гээд байгаа юм. Тэгэхээр яах вэ би бол цөөнхийг хамгаалаад байгаадаа биш. Парламентад угаасаа бусад улс оронд тогтчихсон, ингээд харин ч дөрөвний нэгийг нь бид нар чинь ингээд одоо чангалаад гуравны нэг болгочоод байгаа нь энэ. Гуравны нэг. Одоо бүр манай Байнгын хорооны дарга бол гуравны хоёр бүр олонх гэж байна. Зүгээр л энэ бол энэ хяналтын түр хороог ажиллагаагүй болгоно гэсэн үг. Энэ хороо чинь байгуулагдах нь чухал биш. Гэрчээр дуудна нотлох баримт бид нар чинь хоёр, гурван юмыг нь хасчихаад байна шүү дээ. Хяналт шалгалт томилохыг нь больё, дураараа дуудаад байж болохгүй.

Энэ дээр Мөнхсайхан багш нэг тодруулж хэл дээ.

Үүнийг бол би протоколд энэ хасагдах юм бол энэ өөрөө ёстой нөгөө мөлийлгөсөн гэдэг Бямбацогт гишүүний тэгж хэлээд байгаа шиг харин тэр бол тавин

хувь мөлийлгөнө шүү Үүнийг одоо хэрвээ суллах юм бол энэ жинхэнээсээ мөлийх заалт мөн. Одоо тийм хүсэл байвал тэр одоо би яж мэдэх вэ?

Ж.Мөнхбат: Та нар бодоорой би ванга шиг хэлье. Гуравхан хүн бужигнуулна шүү. Парламентыг Засгийн газрыг чинь цаашдаа. Үгүй ээ үгүй, наадах чинь цөөнх тэртээ тэргүй дэмжинэ шүү дээ. Долоон хүн автоматаар дэмжинэ. Тэгэхээр олонхоос гурван хүн цөөнхийн долоотойгоо нийлээд л түр хорооныхоо арав олонх болоод.

Мөнхсайхан доктор протоколд тэмдэглүүлье гэж байгаа юм.

Ажлын хэсгийн нэг номер.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр энэ 48.2 бол энэ хуулийн төслийн одоо ганц амин сүнс заалт нь. Энэ байхгүй болбол энэ түр хороог байгуулсны ямар ч шаардлагагүй. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн 28.2 дээр Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санаачлах юм бол түр хороог байгуулна. Заавал байгуулах ёстой. Энэ дотроо орж байгаа бүрэлдэхүүн нь өөрөө энэ харьцаанаас доошгүй цөөнх энэ бүрэлдэхүүндээ орж байж тухайн асуудлаар гэрч дуудах, нотлох баримт цуглуулах байдлаар тэр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг бодитой, үндэслэлтэй гаргаж хэлэлцэх. Энэ парламентын хяналтын хамгийн гол заалт нь өөрөө энэ байж байгаа юм. Өөрөөр хэлбэл арван есөөс доошгүй гишүүн гэсэн Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэг ч харьцаа нь өөрөө нотлох баримт цуглуулах дээрээ бас орж байж энэ бол хэрэгжинэ. Тэгэхээр бид нарын жишиг болгож авсан Герман, Австри гээд бүх улсууд бол юу вэ гэхээр дөрвийн нэгээс доошгүй нь түр хороог байгуулаад зогсохгүй түр хорооны бүрэлдэхүүн дэх дөрөвний нэгээс доош хүн нь нотлох баримт цуглуулах эрхийг нь өгдөг. Тэгж байж тэр асуудал дээр үнэн бодитой тэр мэдээллийг цуглуулах боломж олгож байгаа юм. Хэрвээ энэ заалт олонх болоод ч юм уу дийлэнх олонх болох юм бол ер нь энэ процесс өөрөө ажиллахгүй, үүнийг бид нар энэ хуулийг ер нь баталсны ч хэрэг байхгүй. Энэ нь өөрөө Үндсэн хуулийнхаа үзэл санааны эсрэг болчож байгаа юм.

Эцэст нь парламентын засаглал гэдэг бол Парламент дахь олонх цөөнхийн оролцоог хангасан, цөөнхөөс гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг цөөнхийн санаачилгаар хэрэгжүүлдэг энэ процедураар л хэрэгждэг. Бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлачихсан. Ерөнхийлөгч бол хяналт тэнцлийг хангах гэхээсээ илүү арбитрчийн үүрэгтэй. Бид нар сонгодог парламентын засаглал руу явж байгаа бол цөөнхийнхөө зохистой оролцоог нь 48.2-т байгаа шигээр хангаж байж л хяналт тэнцлийг хангана. Тэгэхээр үүнийг хийхгүй бол ер нь энэ одоо хууль маань тэр чигтээ л ажиллахгүй л дээ.

Ж.Мөнхбат: Ажлын хэсгийн гишүүд хариуллаа. Тогтохсүрэн гишүүн санал гаргана.

Д.Тогтохсүрэн: 48-ыг бол дордуулчихсан байхгүй юу. Хууль санаачлагч бол дөрөвний нэг гэдэг тоо оруулж ирсэн. Гэтэл үүнийг гуравны нэг болгочихсон. Хоёрдугаарт нь шийдвэр гаргахыг нь бол 48.2 дээр хууль санаачлаад заагаагүй. Гэтэл энэ дээр болсон чинь шууд 7 хүний эрхийг батлахаар ороод ирчхэж байгаа юм Тийм учраас миний горимын санал ямар санал хэлэх гээд байгаа юм гэхээр гуравны нэгийг нь авъя, хамаа байхгүй. Гэхдээ түр хороо асуудлаа олонхоороо шийддэг энэ л зарчмыг гаргахгүй бол цөөхөн 7 гишүүний тоглолт бол хүчтэй явахаар энд орж байгаа юм. Тийм учраас би ямар санал оруулах гэж байгаа юм гэхээр түр хорооны

гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахтай холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийг олонхын саналаар шийдвэрлэнэ. Ингээд л одоо оруулаад явах юм шүү л гэж бодож байна.

Ж.Мөнхбат: Үгүй ээ, үгүй ийм шүү дээ. Одоо жишээлбэл 19 гишүүний 7 нь цөөнхөөс орж ирнэ. Одоо ингээд нэгэнт гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан юм чинь. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ Тогтохсүрэн гишүүний хэлээд байгаа тэр дөрөвний нэг чинь одоо гуравны нэг дордууллаа, одоо олонхоороо шийднэ гэвэл үгүй. Угаасаа энэ дөрөвний нэгийг тэгвэл хэрэггүй шүү дээ. Ерөөсөө гуравны нэг ч хэрэггүй, тэр дөрөвний нэг ч хэрэггүй. Олонхоороо тогтоол гаргах юм бол энэ заалт ер нь ямар хэрэгтэй юм. Угаасаа л хэрэггүй. Түүнийг таны хэлдгээр гуравны нэг болгоё, тэгэхдээ олонхоор шийднэ гэвэл энэ гуравны нэг чинь өөрөө хэрэггүй. Дөрөвний нэг энэ тэр чинь. Энэ чинь зүгээр л хасалт хийлгэсэнтэй л адилхан шүү дээ, энэ угаасаа байх нь. Энэ чинь гэрчээр дуудах, нотлох баримт гаргуулах асуудал дээр тогтоол гаргах үүрэгтэй гэдэг нь. Тогтоол гаргах үүрэгтэй гэдгийг чинь адилхан тогтоол гарсандаа тооцно гэж байгаа юм.

Тэгээд энэ нотолгооны баримт бүрдүүлэх, гэрчээр дуудах тэр эрхийг нь хангаж өгөхгүйтгээр энэ түр хороо чинь ажиллахгүй. Түүнийг гэрчээр дуудахгүйгээр олгохоор шийдчихсэн юм чинь тэгээд л зогсоо шүү дээ. Тэр ажил чинь. Нөгөө бид хэд зохиолч болоод байгаа юм биш байхгүй юу даа, энэ чинь зүгээр одоо угаасаа л дэлхийд тийм гэж ойлгож байгаа. Тэгэхээр манай улс төлөвшөөгүй гэж байгаа бол хянан шалгах түр хороог одоо энэ хуулийг өнөөдөр батлуулах шаардлага байхгүй болчхоод байгаа юм. Нэг нь төлөвшөөгүй юм чинь одоо уг нь төлөвшье гээд хянаж шалгадаг сонгодог парламентынхаа дараачийн үе шат руу л орьё гэж байгаа юм. Тэгээд энэ механизм чинь хамгийн гол нь байгаа юм.

Ж.Мөнхбат: Одоо ингэнэ шүү дээ. Дэгээр хоёр адилхан санал гаргасан бол нэгээр нь эхнийх нь дэмжигдвэл, хоёр дахь нь 39.18-д ийм байгаа. Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр хоёр ба түүнээс дээш саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй гэсэн 39.18.

Тэгэхээр ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна. Гэхдээ яах вэ, одоо мэдээж ажлын хэсэгт ажилласан учраас манай ажлын хэсгийн ахлагч ингэж хариулаад байгаа юм л даа. Гэхдээ яг энэ гэрчээр дуудах, нотлох баримт цуглуулах, энэ эрхийг нь өгвөл зөвхөн сөрөг хүчний 7 гишүүн тэр 19 дотроо кнопоо дараад байхад л дуудаад байх эрхтэй болж байгаа шүү гэдгийг л хэлээд байгаа юм. Түүнээс тэр олон улсын жишиг, стандартыг ерөөсөө эсэргүүцээд байгаа юм биш. Мөнхөд Монголын парламент ийм харьцаатай явахгүй шүү.

Ингээд ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Үгүй ээ, арай өөр юм байна, өөр олонхын саналаар гээд танилцуулга дээр.

Төслийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3, 48.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

48.2. түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахтай холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны тогтоол гарсанд тооцно.

Санал гаргасан ажлын хэсэг.

Одоо хоёр дахь саналыг танилцуулна. Дэгийн дагуу.

48.2. үр хорооны нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэгдэнэ гэж байгаа юм байна. Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулахтай холбоотой санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгийн гаргасан санал.

Ийм хоёр санал байгаа шүү. Ингээд санал хураалт явуулья. Дэгээр. Гэхдээ одоо эхний ирсэн эхний ажлын хэсгийн саналаар хураана. Хэрвээ ажлын хэсгийн санал дэмжигдвлэл Тогтохсүрэн гишүүний гаргасан санал дэмжигдэхгүйд тооцогдоод явах дэгийн зохицуулалттай.

Санал хураалт, ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулья. Сайн бодоорой, манайхан.

11 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 36.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Энэ бол ажлын хэсгийн санал дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн санал дэмжигдээгүй учраас Тогтохсүрэн гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Ажлын хэсгийн гишүүд та нар нэг юмыг жоохон ойлгох хэрэгтэй шүү дээ. Энэ улс төрийн нөхцөл байдал, амьдрал чинь дандаа ийм юм байхгүй шүү. Занданшатар дарга горимын санал гаргана.

Г.Занданшатар: Энэ санал хураалтыг хүчингүй болгоод дахиж найруулахгүй бол нэг ийм зарчмын хоёр асуудал гараад байна. Ер нь одоогийн Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүн нотлох баримт хаанаас шаардах эрхтэй. Энэ заавал дөрөв, тав ч байх эрхгүй. Нэг гишүүн шаардах хэрэгтэй. Нэг гишүүн ч гэсэн гэрч дуудаж болно. Одоо би Нийтийн сонголтын хуулиар нэг гишүүн ч санал гаргаад, ийнхүү оролцуулья гээд өөрийнх нь саналаар оролцуулж болж байгаа.

Хоёрдугаарт, тэгэхээр одоогийн хуульд ч гэсэн энэ байна шүү дээ. Энэ шинжээч томилох нотлох баримт, ер нь тэгээд нотлох баримт, үнэн зөвийг нотлох баримт гаргахаас юунаас нь айгаад байгаа юм. Энэ бол ингээд Байнгын хороон дээр бараг шүүхийн ялын тогтоол уншиж байгаа юм шиг хүмүүс бас айлгах хэрэггүй л дээ. Нотлох баримт гарахаас юунаас айгаад байгаа юм. Энэ үнэн. Зөв гэсэн аль нь ч цагаатгах зөвтгөх буруутах аль ч талын нотлох баримт гаргуулах саналыг нэг гишүүн гарах биш, дөрөв, таван ч байна уу, зургаа ч юм уу долоон гишүүн гаргаж үнэн зөвийг олох л зорилготой энэ шалгалтад ажил явуулна шүү дээ. Тэр чинь эцсийн шийдвэр биш. Тэр нотлох баримт нь харин үнэн юм уу, зөв юм уу, дэмжих үү? Дэмжихгүй гэдэг олонхын саналаар түр хороо шийдвэрлэнэ. Эцсийн шийдвэр бол эцсийн шийдвэр бол тэр Түр хороо ямар дүгнэлт гаргах вэ, ямар санал дүгнэлт гаргах вэ гэдэг бол

олонхынхоо саналаар шийдвэрлэгдэнэ. Парламентын алтан зарчим бол олонхын саналаар асуудал шийдвэрлэх.

Гэхдээ цөөнхийг хүндэтгэх. Энэ бол ардчиллын болон парламентын ардчиллын үндсэн зарчим. Тэгээд үүнийгээ яг харгалзаж үзээд одоо үүнээсээ ухарч байгаа юм шиг ийм ойлголт ч гэсэн төрүүлэхгүйгээр үүнийг одоо нэг гүйцээж боловсруулаад гүйцээн боловсруулах, тэгээд бас саяын санал хураалтуудыг хүчингүйд тооцоод дахин санал хураалт явуулж энэ ажлын хэсгийн саналаараа бараг тэгээд энэ бол яг гуравны нэг гэхээр долоон гишүүн болж байгаа юм. Энэ дээр бол таван гишүүн санал гаргах болж байгаа юм. Ер нь нотлох баримт шаардах, шинжээч томилох энэ тэрийг нь бол бас шинжээч томилох гэрч дуудахад нотлох баримт гарах хасчихсан юм байна. Тэр хянан шалгагч томилох, газар дээр нь үзэх, бичиг баримтын дүн шинжилгээ хийх энэ тэрийг бол хасаад гуравны нэг л болгож байгаа юм байна л даа, уг нь бол.

Тэгээд одоо энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулж байна.

Ж.Мөнхбат: Их Хурлын даргын хэлж байгаа бол үнэн. Түр хорооны гишүүд, тэр гэрч дуудах, нотлох баримт гаргах, маргахыг шаардах эрхтэй. Үүнийг нь олонхоороо шийддэг л энэ зарчмаараа ардчиллын зарчмаараа л явъя гэж байгаа. Тогтохсүрэн гишүүний гаргаж байгаа санал бол үндсэндээ тэр шүү дээ. Гишүүдийн гуравны нэг нь нотлох баримт шаардах, гэрч дуудах санал гаргаж болно, үүнийг түр хорооны гишүүдийн олонхоор шийдээд явъя гэж байгаа юм.

Ингээд Занданшатар даргын гаргасан горимын саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох тухай санал хураалт явуулъя. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болголоо.

Одоо өмнөх санал хураалт хүчингүй болсон учраас санал хураалт явагдана.

Тогтохсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналыг томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энхболд дарга уг хэлье.

Н.Энхболд: Тодруулахгүй бол болохгүй бас нэг асуудал байгаа юм. Сүхбаатар, Бямбацогт гишүүн ээ, санаачлагч, ажлын хэсгийн ахлагч нар. Энэ нөгөө энэ гэрч дуудна гэж байна шүү дээ. Тэр ерөнхийдөө гэрч дуудъя гэдэг асуудлыг шийдэх юм уу, эсхүл жишээ нь би санал гаргаад, тэгээд одоо 5 хүн нийлж байгаад санал гарна, түүнийг л дуудна гээд. Зорилготойгоор ямар нэг хүн дуудвал яах вэ гээд бас нэг сонин асуудал гарч ирж байгаа шүү. Хамгийн асуудлыг улс төржүүлье ч гэдэг юм уу, бүтэхгүй талаас нь байлгая гэдэг хүнийг үүнийг л дуудна гээд л санал гаргачихвал автоматаар тогтоол гарсанд тооцох нь байна шүү дээ. Тэгээд үүнийгээ тодруулахгүй бол бас болохгүй байх, тэгвэл хэнийг дуудах вэ? Энэ тохиолдолд гэдгээ бас нэг тэр түр хороон дээрээ юм уу, Байнгын хороон дээр ярьж байж дуудахгүй бол тийм асуудал гарна шүү. Тэр чинь нөгөө таван хүн чинь нөгөө цөөхөн хүн чинь л аль болохоор л зөвхөн өөрсдийнхөө гаргаж байгаа байр сууринд таарсан л гэрчээ

дуудахыг бодно шүү дээ. Тэгээд л автоматаар нөгөө хүн нь нэр нь гарлаа. Тогтоол гарсанд тооцогдоо тэр хүн ирлээ. Тэгээд нөгөө миний яриад байгаа улс төржүүлдэг асуудлыг аль болохоор улс төрийн хэрэг болгодог. Ашиг сонирхолтой нийцүүлдэг энэ юм бас гарах нэг ийм нүх үлдчих вий дээ. Үгүй ээ, санал гаргавал автоматаар тогтоол гарна гэж байгаа шүү дээ.

Ж.Мөнхбат: Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: энэ ийм шүү дээ, одоо шулуухан хэлчихье, тэгвэл. Хянан шалгах түр хороо бол цөөнхийн зэвсэг мөн үү, мөн. Тэгэхдээ энэ түр хороог байгуулж байгаа цөөнх ямар сонирхолтой мотивтай байдаг вэ гэхээр энэ асуудлыг шийдүүлэх сонирхолтой байдаг. Энэ түр хороо бол хоёр асуудлыг шийдэж байгаа юм. Нэг нь бол гудамжинд улс төр хийх боломжгүй болгож, парламентын тогоон дотор бусдыг хийлгэх боломжийг нь олгож байгаа нэгд.

Хоёрт, гэрч дуудаад байна гэж. Энэ зүгээр гэрч дуудна. Шинжээч л томилно. Гэрчийг нь дуудуулахгүй, өөрсдөө бужигнуулаад л ирж дуудаад. Ингээд л янзын гэрч дуудаад байх юм бол энэ процесс сулраад яваад юм уу. Тэнд улс төр хийгээд байх тийм аюул байхгүй. Гэрч дуудаад байна. Тэрийг сунжуулаад байх юм. Олонход сунжуулаад байх нь тийм ашигтай юм уу. Ашигтай шүү дээ. Тэгвэл бүр эсрэгээр нь хэлье. Одоо тэгж л ярих гээд байна л даа. Энэ чинь олонх, энэ түр хороо чинь асуудлыг аль болохоор ингээд одоо нөгөө цөөнх чинь асуудлаа шийдүүлээд ингээд явах гэж байгаад. Тэгэхд гол нь тэр гэрчүүд орж ирээд шинжээч орж ирээд юм ярихаар олон нийт хараад байна. Тэгэнгүйт нь олонх нь өөрийнхөө аргументыг бас гэрчээ дуудаад л, шинжээчээ томилоод л адилхан ингээд л яваад байна. Энд улс төр хийгдэж байна уу? Хийгдэнэ. Үүнээс айгаад яах вэ. Энэ улс төр хийсэн ч гэсэн энэ дотор гэрчийг дуудаад шинжээч томилоход нотлох баримтуудыг гаргаж ирэхэд энэ олонход ч энэ ашигтай, цөөнхөд ч ашигтай. Эцсийн дүндээ аргументаар хоорондоо байлдаж байгаа шүү дээ. Энэ чинь аргумент дээр. Асуудлыг хурдан дуусгах сонирхол цөөнхөд илүү байгаа. Яс юман дээрээ. Гэрч, нотлох баримтыг тэгээд сунжуулаад л цөөнхөд. Ингээд л байвал энэ чинь цаг хугацаатай. Жилийн хугацаанд нэг удаа сунгадаг.

Тэгээд түр хороо байгуулах санал чинь цөөнхөөс гарч байгаа шүү дээ. 19-өөс доошгүй гишүүн хэдийгээр олонх байсан ч гэсэн олонхын цөөнхөөс гарна. Цөөнхийн цөөнхөөс гарна, эсвэл цөөнхүүд хамтарч гаргана. Тэгээд энэ чинь гудамжинд гарахгүй байх сонгодог парламентын цаад нөгөө ил харагдахгүй байгаа хэсгээрээ бол олонход ашигтай. Цөөнхөд ашигтай гэсэн хоёр юм нь энэ дээр балансалж гарч ирж байгаа юм. Түүнээс биш яг энгийнээр бодоход ингээд л гэрч дуудах шинжээч томилохос олонх нь ч айгаад, цөөнх нь баахан олон гэрч дуудна гээд. Олонх нь ч гэрчээ дуудна, нотлох баримтаа гаргана, цөөнх ч гаргана. Энд мэтгэлцээд л явна шүү дээ.

Ж.Мөнхбат: Бямбацогт гишүүн горимын санал.

С.Бямбацогт: Ерөнхийдөө сая Сүхбаатар гишүүн тодорхой хэллээ. Энэ гуравны нэг нь байна уу, дөрөвний нэг нь байна уу, шийдвэр гараад асуудал шийдэгдэх юм ерөөсөө биш. Зөвхөн гэрчийг дуудах тэр нотлох баримт цуглуулах энэ процесс. Олонхын гишүүдээс ч тэр, цөөнхийн гишүүн аль аль нь л явна. Эцэстээ шийдвэр хэзээ гарах вэ гэхээр шийдвэр түр хороон дээр гарна. Эцсийн шийдвэрийг

түр хорооны гишүүдийн олонхоор гарна. Ийм юм. Ганцхан гэрчийг дуудах, нотлох баримт цуглуулах, шинжээч томилох гэдэг энэ процессууд дээр л гуравны нэг байх уу, дөрөвний нэг байх уу гэсэн асуудал яригдаад байгаа юм. Тэгээд энэ дээр нэг их маргаад яах вэ. Тийм ач холбогдолтой юм бас биш. Жижигхэн ач холбогдол багатай юмыг эцсийн шийдвэрийг түр хорооны олонхоор гарна. Ийм юмыг их том улс тэр болгоод, их том хадны мангас болгоод л их том асуудал болгож яриад байхаа больё. Одоо эцэстээ явж байгаа одоо миний санаачилсан хууль бол тэр л дээ.

Тийм болохоор би горимын санал гаргаж байгаа нь саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч ээ. Тогтохсүрэн гишүүний Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн даргын гаргасан саналаар явчихъя. Үүгээр одоо санал хураалгаж өгөөч гэсэн горимыг нь гаргаж байна.

Ж.Мөнхбат: Бямбацогт гишүүн горимын санал гаргалаа. Горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт горимын саналыг дэмжье. Энэ нь өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн.

10-аас 7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бямбацогт гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас Тогтохсүрэн гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 49 дүгээр зүйл дээр санал алга байна.

Төслийн 50 дугаар зүйл дээр алга байна.

Төслийн 51 дүгээр зүйл дээр алга байна.

Төслийн 52 дугаар зүйл дээр алга байна.

Төслийн 53 дугаар зүйл дээр алга байна.

Төслийн 54 дүгээр зүйл дээр алга байна.

Төслийн 55 дээр ажлын хэсгийн санал.

Төслийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтын “газар дээр нь очиж үзэх” гэснийг “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах” гэж өөрчлөх ажлын хэсгийн санал.

Санал хураалт.

10 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

Нэг. Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь гишүүний гэсний өмнө энэ хуулийн 13.4-т заасны дагуу гаргасан гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

10 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.1 дэх заалтын “хууль ёсыг” гэснийг “хуулийг” гэж, мөн зүйлийн 4.1.2, 4.2.2 дахь заалтын “хангах” гэснийг “хамгаалах” гэж 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь хэсгийн “хэтрүүлж байсныг” “хожимдож” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “тодорхой” гэснийг “хуульд заасан” гэж, мөн хэсгийн “хурал” гэснийг “хурлаас” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3, 44.6, 44.7, 44.8, 44.11, 45 дугаар зүйлийн 45.4, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн

51 дүгээр зүйлийн 51.1, 52 дугаар зүйлийн 52.1, 52.5, 54 дүгээр зүйлийн 54.1, 55 дугаар зүйлийн 55.3, 55 дугаар 55.6, 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2, 61.4, 67 дугаар зүйлийн 67.2, 67.5, 67.6, 68 дугаар зүйлийн 68.1, 68.3, “хэсгийн мөрдөн” гэснийг “тусгай” гэж тус тус үйлчлэх.

Гурав. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “мөрдөн шалгах” гэснийг 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4, 20.5, 20.6, 20.7 дахь хэсгийн дээд хэсгийг тус тус гаргах

Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт.

Найруулгын санал учраас хамтад нь санал хурааж байна.

10 гишүүнээс 9 дэмжиж, 90 хувийн саналаар дэмжлээ.

Төслийн дараах томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу, алга байна.

Хоёр дээр алга байна.

Гурав дээр алга байна.

Дөрөв дээр алга байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай зүйлийн 1 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна. Ингээд зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хяналт шалгалтын тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? алга байна.

2 дээр алга байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл заалт дээр асуулт, саналтай гишүүн байна уу алга байна.

2 дээр алга байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, алга байна.

2 дээр алга байна. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай төсөл хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

3 дээр алга байна. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж, бас хэлэлцэж дууслаа.

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

3 дээр алга байна. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

3 дээр алга байна.

4 дээр алга байна. Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

3 дээр алга байна. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Статистикийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, алга байна.

2 дээр алга байна. Статистикийн хуулийн нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр заалт дээр асуулт, саналтай гишүүн байна уу, алга байна.

2 дээр алга байна. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, алга байна.

2 дээр алга байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр алга байна.

3 дээр ажлын хэсгийн санал байна.

Ажлын хэсгийн санал.

Нэг. Төслийн 3 дугаар зүйлийн 18 дугаар зүйлийн 18.5 гэсний дараа 18.7 гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “олонх” гэсний “гуравны нэгээс доошгүй гэж” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар өмнөх санал хүчингүй болж байна.

Одоо санал хураалт явуулъя.

Төслийн сая дээр дурдсан ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Төслийн 3 дугаар зүйлийн гуравны нэгээс гэснийг 9-өөс, 5-аас гэснийг 9-өөс гэж тус өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг.

Санал хураалт.

7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Ажлын хэсэг.

Санал хураалт.

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

8 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зүйлийн 6 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, Алга байна.

2 дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу, алга байна.

2 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

3 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

3 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

4 дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Прокурорын тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байнгын хороо хураасан байна. 10 сарын 27-нд.

Дараагийн 2 дугаар зүйл дээр Байнгын хороо хураасан.

3 дугаар зүйл дээр Байнгын хороо хураасан.

4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? санал хураасан байна. 5 дугаар зүйл дээр Байнгын хороо хураасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Тогтоол хүчингүй болсон тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Ажлын хэсэгт, Нямдорж -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Зохицсүрэн- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бодлого зохицуулалтын газрын дарга, Мөнх-Эрдэнэ -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Батжаргал -Үндэсний хөгжлийн газрын дарга гэсэн ийм ажлын хэсэг ирсэн байна.

Танилцуулгыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэнд хүргэсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа гэсэн танилцуулга байна.

Асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг гишүүн танилцуулчих.

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА